



КОВИД 19 ЦАР ТАХАЛ ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГАА

МОНГОЛ УЛС: ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБА ХААГЧДЫН ҮЙЛДСЭН
ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ, ТОХИОЛДОЛ

Нүүрэн талын зургийн тайлбар:

© www.mra.mn. 2021 оны 1 дүгээр сарын 25.

Төв талбайд жагсагчид дундаас КОВИД-19-ийн сэжигтэй тохиолдол илэрлээ.

АГУУЛГА

1. ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
2. ТАНИЛЦУУЛГА	5
3. АРГА ЗҮЙ	6
4. ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХУУЛЬ, ХЭМ ХЭМЖЭЭГ ЗӨРЧСӨН ХУУЛЬ, БОДЛОГО	7
5. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА АЛБА ХААГЧДЫН ҮЙЛДСЭН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ	10
5.1 ЖАГСААЛ ЦУГЛААНЫГ ЗӨВ ЗОХИСТОЙГООР ЗОХИЦУУЛЖ ЧАДААГҮЙ НЬ	10
5.1.1 Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хууль бусаар хязгаарласан нь	12
5.1.2 Ялгавартай хандсан нь	13
5.1.3 Эрсдэлд хүргэсэн нь	16
5.1.4 Жагсаал, цуглааныг тараахдаа хууль зөрчсөн нь	17
5.2 ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ АЖИЛЛАГАА	19
5.3 ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙГ ТАНИХ, ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ БАЙДАЛ	21
5.4 ЭСЭРГҮҮЦЭЛ, ШҮҮМЖЛЭЛИЙГ НУХЧИН ДАРСАН НЬ	22
5.5 ЦАГДААГИЙН ХҮЧ АЛБАДЛАГЫГ ХЭТРҮҮЛЭН ХЭРЭГЛЭСЭН НЬ	25
5.5.1 Ялгаварлан гадуурхсан нь	25
5.6 ХҮНЛЭГ БУС ХАРЬЦАА	27
6. ДОТООДЫН ЗОРЧИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЯЗГААРЛАЛТ	29
7. ОРОН ГЭРГҮЙ ИРГЭДИЙГ ТУСГААРЛАСАН БАЙДАЛ	32
8. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	34
8.1 СОНСОГЧДЫГ ДАЙЧИЛСАН БАЙДАЛ	34
8.2 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ХАМГААЛАЛ	35
9. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ МЕХАНИЗМ	38
9.1. ЦАР ТАХЛЫН ҮЕД ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГОМДОЛ ГАРГАХ, ШИЙДВЭРЛЭХ, ХУУЛЬ ЗӨРЧСӨН АЛБА ХААГЧИД ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ МЕХАНИЗМ	38
10. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	40

1. ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ЖЦХЖТХ	Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль
ИУТЭОУП	Иргэний болон улсын төрийн эрхийн тухай олон улсын Пакт
Ковидын хууль	Коронавируст халдвар (Ковид -19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
ЛГБТИ	Лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсексуал
МҮОНРТ	Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
МЭИ	Монголын Эмнести Интернэшнл
МЭМАҮЭХ	Монголын Эрүүл Мэндийн Ажилтны Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбоо
НОК	Нийслэлийн онцгой комисс
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
UNODC	НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба
ПГУ	РСР
УОК	Улсын онцгой комисс
УИХ	Улсын Их Хурал
ХДХВ	Хүний Дархлал Хомсдолын Вирус
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ХЭК	Хүүхдийн эрхийн тухай конвенц
ХЭТТ	Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭЗНСЭОУП	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт

2. ТАНИЛЦУУЛГА

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал нь нийгмийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулж, нийгэм, эдийн засгийн харилцааны бараг бүх түвшинд шийдвэрлэвэл зохих олон төрлийн сорилт, тулгамдсан асуудлыг бий болгож байна. Цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, нийтийн хэв журам хамгаалах зорилгоор улс орнууд иргэдийн зорчих хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, өдөр тутмын нийтлэг үйлчилгээ, уулзалт цуглаан, шашны зан үйл зэрэг хүний амьдралын олон салбарт хязгаарлалт тогтоосон.

Зарим улс цар тахлын эсрэг тэмцэлд олон нийтийн идэвхи оролцоог дэмжих чиглэлд ихээхэн анхаарч, итгэлцэл, эв нэгдлийг бий болгоход чиглэсэн бодлого, зохицуулалтыг баримталж¹ байгаа бол зарим улс цар тахалтай тэмцэх нэрийдлээр хүний эрхэд үндэслэлгүй бөгөөд хэт хязгаарлалт тогтоож, нийгмийн шүүмжлэлт дуу хоолойг нухчин дарах гэх зэрэг зүй бус зорилгоор хууль сахиулах байгууллагын хүч, хэрэгсэл, албадлагын арга хэмжээг нөхцөл байдлын хэр хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэж байна. Ялангуяа Өмнөд Африк, Нигер, Кени, Филиппин, Шри Ланка, Эл Сальвадор, Доминиканы БНУ, Перу, Гондурас, Йордан, Марокко, Камбож, Узбекистан, Иран, Унгар зэрэг улсад цар тахлын үед тогтоосон онц байдлын үеийн дэглэмийг ялимгүй зөрчсөн, үзэл бодлоо илэрхийлэх зорилгоор халдвар хамгааллын аюулгүй байдлаа ханган цугласан иргэдийг баривчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг өргөн хүрээнд зүй бус байдлаар ашиглаж, зарим тохиолдолд дотоодын цэрэг армийг хүний эрхийг зөрчих зорилгод ашиглаж байгааг НҮБ болон хүний эрхийн бусад байгууллагууд шүүмжилсээр байна.²

Цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах явцад албадлагын арга хэмжээг хэтрүүлэн ашиглах нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн, баримтад суурилсан сайн туршлагатай харшлахын зэрэгцээ нийгмийн эмзэг бүлгүүдийн дунд айдас бий болгох, цаашлаад эрх баригчдад итгэх итгэлийг бууруулахад хүргэдэг. Иймд эрүүл мэндийн хямралын эсрэг хариу арга хэмжээ нь хүний эрхийг хүндэтгэсэн, олон нийтийн идэвх оролцоог дэмжсэн, итгэлцэл, эв нэгдлийг бий болгож чадахуйц бодлогод суурилвал үр дүнтэй.

Хууль сахиулах байгууллагын алба хаагчид бүрэн эрхээ хэтрүүлсэн, хууль бусаар ашигласан тохиолдолд тэрхүү үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх нь хууль дээдлэх зарчимд нийцнэ. Харин дээрх хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлж, таслан зогсоохын тулд хөндлөнгийн хяналт шалгалт, хараат бус гомдол барагдуулах механизмыг бий болгож, гэм буруутай этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх явдлыг төрөөс баталгаажуулах нь чухал. Иймээс цар тахлын үед хууль сахиулах байгууллагын хүч, албадлагыг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн хуулийн хүрээнд ашиглах, цар тахлын үеийн хууль сахиулах үйл ажиллагаанд хүний эрхийг дээдэлсэн хууль тогтоомжийг батлах, хүний эрхийг зөрчсөн төрийн байгууллага, албан хаагчдын хууль бус үйл ажиллагааг мөрдөн шалгах, тэдгээрт хуулийн хариуцлага ногдуулах замаар хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх үр нөлөөтэй механизмыг бий болгохыг хүний эрхийн байгууллагууд шаардаж байна.

Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдал зарласан нь хууль сахиулагчдад эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ хүний эрхийг хамгаалах, ашиг сонирхлын тэнцвэрт байдлаа хадгалах үүргээс нь чөлөөлөхгүй. Энэ мониторингийн хүрээнд зөвхөн цагдаагийн байгууллага, алба хаагчдын Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хүрээнд гүйцэтгэж байгаа хууль сахиулах үйл ажиллагаанд Монголын Эмнести Интернэшнл дүн шинжилгээ хийсэн болно. Үүнд холбогдох хууль тогтоомж нь олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэх, мөн цагдаагийн байгууллага, алба хаагчид гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед үүрэг гүйцэтгэх явцдаа хүний эрхийн хэм хэмжээг хангаж ажилласан эсэхийг нягталлаа.

Судалгааны хүрээнд бид олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээг зөрчсөн хууль, бодлого хэрэгжиж байгааг, мөн цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйлдсэн хүний эрхийн тодорхой зөрчлүүдийг илрүүлсэн болно. Үүнд иргэдийн тайван журмаар зохион байгуулсан жагсаал цуглааныг хууль бусаар албадан тараасан, зохион байгуулагч оролцогчдыг үндэслэлгүйгээр баривчилж, цагдан хорьсон, хүч хэтрүүлэн хэрэглэсэн, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцсан, цахим орчинд цагдан хянасан, хувь хүний хуулиар хамгаалагдсан мэдээллийг олон нийтийн хэрэгслээр дэлгэсэн, ялгаварлан гадуурхагдах нөхцөлийг бүрдүүлсэн зэрэг зөрчлийг баримтжууллаа.

¹ Эмнести Интернэшнл, Коронавируст халдварт /Ковид-19/-тай тэмцэх хариу арга хэмжээ: Дэлхий нийтийг хамарсан цар тахал болон цагдаагийн байгууллага, албан хаагчдын үйлдсэн хүний эрхийн зөрчил, тохиолдол,

² UN raises alarm about police brutality in COVID-19 lockdown, 28 Apr 2020, <https://www.aljazeera.com/news/2020/4/28/un-raises-alarm-about-police-brutality-in-covid-19-lockdowns>

3. АРГА ЗҮЙ

Монголын Эмнести Интернэшнлээс Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгээр Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний үеэрх цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийлээ. Энэхүү судалгааны хүрээнд 2020 оны 2 дугаар сараас 2021 оны 12 дугаар сар хүртэлх хугацааг хамруулан хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд мониторинг хийх, бусад холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүнтэй уулзах зэргээр мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.

Судалгаанд тусгасан мэдээ мэдээллийг өдөр тутмын хэвлэлийн мэдээ, бусад олон талт эх сурвалжуудаар баталгаажуулсан. Ковид 19 цар тахлын үеийн зорчих хөдөлгөөний хязгаарлалтын улмаас судлаачид тухайн газар дээр нь очиж мэдээлэл цуглуулах боломжгүй байсан ч холбогдох хувь хүн, хүний эрхийн зөрчлийн хохирогчид, хуульчидтай утсаар холбогдож, цахим болон биечилсэн уулзалт хийлээ. Мөн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хүрээнд гаргасан хууль тогтоомж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван замаар эвлэлдэн нэгдэх эрхийн хэрэгжилт болон, жагсаал цуглааны үеэрх нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаа нь олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд нийцсэн эсэхийг шинжлэв.

Тайланд оруулсан жишээ тохиолдлыг бодлого зохицуулалтын хувьд шийдвэрлэвэл зохих, холбогдох байгууллагад санал зөвлөмж гаргахад хамааралтай, хууль тогтоомжийн хэрэгжилтэд цаашид анхаарвал зохих зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан сонгосон болно.

4. ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХУУЛЬ, ХЭМ ХЭМЖЭЭГ ЗӨРЧСӨН ХУУЛЬ, БОДЛОГО

Олон улсын хүний эрхийн суурь гэрээ, конвенцоор хүн бүрийн тэгш эрхийг баталгаажуулсан. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын дагуу оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрөгдсөн эрхийг арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй. Эдгээр олон улсын хууль, хэм хэмжээ хямралын үед ч мөн хүчин төгөлдөр үйлчлэх ёстой.

Хүний зарим эрхийг хуулиар хязгаарлаж болох ч энэ нь үндэслэл бүхий, зайлшгүй бөгөөд хэр хэмжээнд нийцсэн байх шаардлагатай. Нийтийн эрх ашгийг хамгаалах туйлын зорилгодоо нийцээгүй, зорилгоосоо хазайсан, эсхүл тэрхүү зорилгынхоо эсрэг чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлснийг дээрх зарчмыг зөрчсөн үйлдэл хэмээн үзнэ.

Монгол улсад Ковид-19 цар тахлаас нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүний эрхийг хязгаарлах журам, баримтлах зарчим, хязгаарлалтад тавих хяналтын талаарх эрх зүйн зохицуулалтын тодорхойгүй байдал нь хүний эрхийг өргөн хүрээнд зөрчих, төрийн байгууллагаас холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байв.

Улсын Их Хурлаас 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг (Ковидын хууль) баталсан. Энэ хуулийн 5 дугаар зүйлд цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлсон нь хүний эрхийг хамгаалахад чухал зохицуулалт болсон.

Ковидын хуулийн 11 дүгээр зүйлд эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд заавал хангавал зохих хууль зүйн шаардлагыг тодорхойлсон³ бөгөөд төрийн холбогдох байгууллага, албан тушаалтнаас гарах шийдвэр, арга хэмжээ нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгийн бага хязгаарласан, зайлшгүй, тохирсон байхаар хуульчилсан.

Гэвч Ковидын хуульд хүний хувийн нууцыг хамгаалах, хувийн мэдээллийг тараахгүй байх, хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжлохгүй байх, хууль зүйн баталгааг хангалттай, тодорхой хуульчлан зохицуулаагүйгээс цар тахлын халдвар авсан, ойрын хавьталд орсон, түүнчлэн хөл хорионы болон хязгаарлалтын дэглэм зөрчсөн иргэдийн талаарх хувийн мэдээлэл олон нийтэд цацагдаж, тэдгээр иргэдийг олон нийтийн зүгээс ялгаварлах, алагчлах, нэр хүндийг нь гутаах зэрэг тохиолдол цөөнгүй гарсан. 2021 оны 1 дүгээр сард Ковидын хуульд нэмэлт оруулж коронавирусний халдвар авсан болон халдвар авсан байж болзошгүй иргэний хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах, иргэний хувийн болон гэр бүлийн нууцыг задруулахаас сэргийлэх, аливаа байдлаар ялгаварлан гадуурхагдах, нэр төрийг нь гутаан доромжлох нөхцөлд хүргэхгүй байх шаардлагыг хуульчилсан.

Цар тахлын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлд хэвлэл мэдээллийн байгууллага нь цар тахлын нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг баталгаат эх сурвалжаас авч олон нийтэд хүргэх үүрэгтэй байхаар заасан нь хэвлэлийн эрх чөлөөг илэрхий зөрчиж, иргэдийн олон арга хэрэгслээр мэдээлэл хайх, олж авах, түгээх эрх, цаашлаад цар тахлын хариу арга хэмжээтэй холбоотой

³ Эдгээрт, 1) Хуульд заасан үндэслэл, журмын дагуу гарсан байх, 2) Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, эрүүл мэнд, эсхүл хүний бусад эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх, 3) Дээрх зорилгод зайлшгүй, тохирсон байх, 4) Хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрхийг хөндөөгүй байх, 5) Хүнийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол боловсролоор болон бусад шинжээр нь ялгаварлан гадуурхахгүй, нэр төрийг доромжлохгүй байх, 6) Коронавирусний халдвар авсан, халдвар авсан байж болзошгүй иргэний хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах, иргэний хувийн болон гэр бүлийн нууцыг задруулахаас сэргийлэх, аливаа байдлаар ялгаварлан гадуурхагдах, нэр төрийг нь доромжлох нөхцөлд хүргэхгүй байх.

төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны үр нөлөөг шүүн хэлэлцэх, санал, шаардлагаа гаргах зэргээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөнд хэт буюу зохисгүй хязгаарлалт тогтоожээ. Түүнчлэн төрийн байгууллагын олон нийтэд өгч байгаа мэдээллийн үнэн зөв эсэхийг хянах хөндлөнгийн үр дүнтэй механизм байсангүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хуульчлан баталгаажуулсан бөгөөд 1994 онд батлагдсан Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар нарийвчлан зохицуулж байна. Гэвч уг хуулиар жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, дэмжих талаарх төрийн чиг үүргийг олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд нийцүүлэн ойлгомжтой, тодорхой хуульчлаагүйн зэрэгцээ жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хэрэгжүүлэх боломжийг “зөвшөөрлийн тогтолцоогоор” хязгаарласан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зүй бусаар хязгаарлах суурь нөхцөлийг бүрдүүлж байна.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 8 дугаар зүйлд улс орны буюу тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшиг (нийтийг хамарсан гоц халдварт өвчин) тохиолдсон бол уг шалтгаан арилтал жагсаал, цуглаан хийхийг хоригложээ. Цар тахлын үеийн аюул, эрсдэлийн түвшин, халдвар хамгааллын аюулгүй байдлыг сахих боломж зэргээс үл хамааран тайван хуран цуглах эрхийг гамшгийн шалтгаан арилтал тодорхой бус хугацаагаар хориглосон нь хүний эрхийг хязгаарлахад баримтлах суурь зарчим болох хүний эрхийг хязгаарлах зорилгод хүрэхэд зайлшгүй бөгөөд гарцаагүй байх, тухайн нөхцөл байдалд тохирсон байх шаардлагад нийцэхгүй байна.

Түүнчлэн Нийслэлийн Засаг дарга хуулиар тусгайлан эрх олгогдоогүй байхад нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд жагсаал, цуглаан зохион байгуулахыг хориглож, жагсаал, цуглааныг бүртгэхгүй байхыг Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон дүүргийн засаг дарга нарт даалгасан нь хууль дээдлэх зарчим, хүний эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах талаарх хүний эрхийн олон улсын хэм хэмжээг ноцтой зөрчлөө. Жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг бүртгэхийг ийнхүү хориглосноос иргэд, төрийн бус байгууллагууд халдвар хамгаалал, аюулгүй байдлаа сахин тайван хуран цуглах эрхээ хэрэгжүүлснийхээ төлөө Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль болон Гамшгийн тухай хууль зөрчсөн гэх үндэслэлээр Зөрчлийн тухай хуулиар шийтгүүлжээ.

Цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хөл хорио болон хязгаарлалтын дэглэм тогтоох зэрэг зохион байгуулалтын үйл ажиллагааг Гамшгийн тухай хуулиар голлон зохицуулж байна. Ковид-19 цар тахал зэрэг хүнд голомтлон тархдаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаарх харилцааг уг хуулиар нарийвчлан зохицуулаагүй байсан тул 2020 оны 4, 5 дугаар сард дээрх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж гамшгийн үед төрийн байгууллага, албан тушаалтны гаргах аливаа шийдвэр, арга хэмжээнд тавих шалгуурыг хуульчилсан.

Гэвч Засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллагаас гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хот хоорондын зорчих хөдөлгөөнийг хязгаарлах зэрэг шийдвэр гаргахдаа энэ тухай нийтэд хүртээмжтэй арга хэлбэрээр боломжит хугацааны өмнө урьдчилан мэдээлэх, зорчих хөдөлгөөнийг хязгаарлахад баримтлах журам зэрэг харилцааг хуульчлан зохицуулаагүй. 2020 оны 11 дүгээр сард Засгийн газраас гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжиж, орон нутаг хооронд зорчих хөдөлгөөн хязгаарлах тухай шийдвэрийг гаргахдаа энэ тухай олон нийтэд боломжит хугацааны өмнө мэдээлээгүйгээс хэдэн мянган иргэн нийслэл болон орон нутаг хооронд зорчих боломжгүйгээр олон хоног саатаж эрх, ашиг сонирхол нь ноцтой зөрчигджээ.

2002 оны Эрүүгийн хуульд “гүтгэх” үйлдлийг гэмт хэрэгт тооцдог байсныг 2017 онд хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуулиар халсан нь үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх, мэдээллийн эрх чөлөөг хамгаалахад чухал алхам болсон. Гэвч 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” үйлдлийг гэмт хэрэгт тооцох болсон нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарлаж, эрх зүйн зохицуулалт дэвшилттэйгээр өөрчлөгдөх үзэл санаанд харш үйлдэл болсон. Мөн Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 5.13.1 дэх хэсэгт Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээллийг түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол торгуулийн шийтгэл ногдуулахаар хуульчилжээ. Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийн дээрх заалтыг цар тахлын үед төр, засгийн газрын холбогдох байгууллагын шийдвэр, үйл ажиллагааг шүүмжлэн, үзэл бодол, санал шаардлагаа илэрхийлсэн иргэдийн дуу хоолойг нухчин дарах хэрэгсэл болгон ашиглалаа.

Цар тахлын үед иргэн, хуулийн этгээдийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах, хөл хорио болон хязгаарлалтын дэглэмийг сахиулах, нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэх зэрэг чиг үүргийг цагдаагийн байгууллага хэрэгжүүлсэн. Цагдаагийн байгууллагаас дээрх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрхийн суурь зарчмыг ямагт дээдлэхийн сацуу халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд нөхцөл байдалд хүлээцтэй хандаж ашиг сонирхлоо зөв тэнцвэржүүлэн хүч, албадлага хэрэглэхээс аль болох зайлсхийж, хүлцэн тэвчих шаардлагатай. Харин холбогдох дүрэм, журмаар дээрх үүргийг баталгаажуулах ёстой.

Цагдаагийн байгууллага, алба хаагчийн хууль сахиулах ажиллагааны процессыг хуулиар нарийвчлан зохицуулаагүй нь манай улсын хувьд томоохон сорилт юм. Цар тахлын үед цагдаагийн алба хаагч чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэх талаар Цагдаагийн албаны тухай хууль, Ковидын хуулиар нарийвчлан зохицуулаагүй бөгөөд Цагдаагийн үйл ажиллагааны журам зэрэг баримт бичигт өөрчлөлт оруулсан талаарх мэдээлэл судалгааны явцад олдсонгүй.

Ковидын хуульд зарим төрлийн харилцаанд мөрдөх журмыг Цагдаагийн төв байгууллага болон бусад холбогдох байгууллага хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавихаар хуульчилсан.⁴ Гэвч 2021 оны 4 дүгээр сарын байдлаар Ковидын хуулийн 8.18-д заасан “Халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах журам”,⁵ мөн хуулийн 9.23-д заасан “Цар тахлын үед Засгийн газар, төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй цар тахлын хүрээг тогтоохтой холбоотой тоон мэдээ, мэдээллийг шуурхай солилцох журам”⁶ батлагдаагүй байсан нь холбогдох төрийн байгууллага үйл ажиллагаагаа дур зоргоороо хэрэгжүүлэх, улмаар иргэдийн хувийн нууцтай байх эрхийг зөрчих, холбогдох хууль, эрх бүхий байгууллагын шийдвэрийг буруу тайлбарлан хэрэглэх, иргэдтэй харилцах харилцаанд үл ойлголцол, маргаан, зөрчил үүсэх нөхцөлийг бүрдүүлжээ.

⁴ Коронавируст халдвар (Ковид -19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9.13-т “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журмыг Цагдаагийн төв байгууллага Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана”, мөн хуулийн 9.18-д “Халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах журмыг Улсын ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газрын болон Цагдаагийн ерөнхий газрын дарга хамтран батална.”, 9.23-д “Цар тахлын үед Засгийн газар, төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй цар тахлын хүрээг тогтоохтой холбоотой тоон мэдээ, мэдээллийг шуурхай солилцох журмыг Цагдаагийн төв байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана” хэмээн тус тус хуульчилсан

⁵ Уг журмыг цар тахлын эсрэг хууль батлагдсанаас хойш 1 жилийн дараа буюу 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн Улсын ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарын хамтарсан А/72, А/63, А/151 дүгээр тушаалаар баталсан.

⁶ Уг журмыг цар тахлын эсрэг хууль батлагдсанаас хойш 1 жилийн дараа буюу 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга нарын хамтарсан А/72, А/63, А/151 дүгээр тушаалаар баталсан

5. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБА ХААГЧДЫН ҮЙЛДСЭН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ

Хууль сахиулах байгууллага, алба хаагчдын зүгээс нийгмийн эрүүл мэндийг хамгаалахдаа хүний эрхийг харьцангуй бага хэмжээгээр хязгаарлах бусад арга хэрэгслийг ашиглахын оронд албадлагын арга хэрэгслийг нэн тэргүүнд ашиглахыг илүүд үзэж, практикт хэрэгжүүлж байгаад Монголын Эмнести Интернэшнл сэтгэл зовниж байна. Цагдаагийн байгууллагаас Ковид-19 цар тахлаар шалтаглан иргэдийг үндэслэлгүйгээр баривчлах, цагдан хорихоос авахуулаад хуулиас гадуур хүч албадлага хэрэглэх зэргээр хүний эрхийг зөрчсөн үйлдэл цөөнгүй гаргалаа. Нэн ялангуяа тайван жагсаал, цуглааныг тараахдаа зохион байгуулагч болон оролцогч иргэдтэй хүнлэг бус, зүй бусаар харьцлаа.

5.1 ЖАГСААЛ ЦУГЛААНЫГ ЗӨВ ЗОХИСТОЙГООР ЗОХИЦУУЛЖ ЧАДААГҮЙ НЬ



Тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй.⁷

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21-р зүйл.

Түүнчлэн жагсаал цуглаан хийх эрхэд хязгаарлалт тогтоох зайлшгүй шаардлагатай эсэхийг үнэлэхдээ эрх баригчид жагсагч олон нийтийн хорио цээрийн дүрэм журмыг сайн дураараа мөрдөн маск зүүж, бие биеэсээ хангалттай хэмжээний зай барин зогсож чадах эсэх зэргийг авч үзэх хэрэгтэй бөгөөд тохирсон зөв үнэлгээг гаргахдаа тайван жагсаал цуглаан хийх эрх, эрх чөлөөний үндсэн ач холбогдлыг хангалттай хэмжээнд харгалзан үзэх ёстой.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө нь иргэд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх, ашиг сонирхлоороо өөр хоорондоо нэгдэх, нийтийн эрх ашгийн асуудлаар аливаа хэлэлцүүлэг өрнүүлэх, санал, шаардлагаа илэрхийлэх арга бөгөөд Үндсэн хууль болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр баталгаажсан улс төрийн үндсэн эрх юм.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад заасны дагуу үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор тайван хуран цуглах эрхэд зөвхөн хуулиар зохих хязгаарлалт тогтоож болох хэдий ч тэрхүү хязгаарлалт нь тухайн нөхцөл байдалд нийцсэн, үндэслэл бүхий, зайлшгүй, гарцаагүй байх зэрэг шаардлагыг хангасан байх ёстой.

Эрх баригчдын хувьд тухайн жагсаал, цуглаан нь аливаа хүчирхийлэл, өдөөн турхиралтад уриалах, эсхүл дайсагнал, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг өдөөнө гэх хангалттай нотлох баримт байхгүй бол тайван замаар явагдана хэмээн үзэж уг эрхэд хүндэтгэлтэй хандах үүрэгтэй.⁸ Хууль тогтоомж зөрчсөн нь тухайн жагсаал, цуглааныг тайван замаар явагдаагүй хэмээн шууд дүгнэж⁹ жагсагчдын эсрэг цагдаагийн байгууллагын хүч, албадлагыг зүй бусаар ашиглах үндэслэл болохгүй.

⁷ See, for example, International Covenant on Civil and Political Rights, <https://treaties.un.org/doc/publication/unts/volume%20999/volume-999-i-14668-english.pdf>

⁸ Тайван хуран цуглах эрхийн асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгч болон Шүүхээс гадуур, дур мэдэн цаазлах асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгчдийн хамтран боловсруулсан "Жагсаал цуглааныг зөв зохистой зохицуулах" тайлан, А/НRC/31/66, 2016 оны 2 дугаар сарын 4, 18 дахь догол.

⁹ Тайван замаар хуран цуглах болон эвлэлдэн нэгдэх эрхийн асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгчийн тайлан, Майна Киан, НҮБ-ын баримт, А/НRC/20/27 (2012) 41 дэх догол.

Тухайлбал, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг бүртгүүлээгүй нь тайван замаар өрнөж буй жагсаал цуглааныг албадан тараах үндэслэл болох ёсгүй.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө нь зорилго, мөн чанарын хувьд олон хүний бөөгнөрөл буюу олон нийтийг хамарсан ердийн арга хэмжээнээс эрс ялгаатай бөгөөд Үндсэн хууль, олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр тусгайлан хамгаалагдсан улс төрийн үндсэн эрх, хүний эрхийг хөхиүлэн дэмжих, ардчилсан үнэт зүйлсийг хамгаалах хэрэгсэл болохыг цар тахлын үеийн хууль сахиулах ажиллагаанд сайтар харгалзан үзэх учиртай.

Түүнчлэн тайван жагсаал, цуглааныг хязгаарлах, тараах эсэхийг шийдвэрлэхдээ тухайн тохиолдол бүрийн онцлогт тохирсон эрсдэлийн үнэлгээг хүний эрхийн шалгуур үзүүлэлтийн дагуу хийх шаардлагатай.¹⁰ Ингэхдээ халдвар, хамгааллын болон хүн хоорондын зай барих зэрэг зайлшгүй дэглэмийг хэрэгжүүлэх боломж, жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний ач холбогдлыг харгалзан үзнэ.

Монгол улсад цар тахлын үед жагсаал, цуглаан хийх эрх чөлөөнд хууль болон бусад байгууллагын шийдвэрээр өргөн хүрээний хязгаарлалт тогтоосон хэдий ч иргэд жагсаал, цуглаан, өлсгөлөн, суулт зэрэг уламжлалт арга хэрэгсэл болон флаш моб, иргэний үл захирагдахуй, хөдөлмөрийн багаж, хэрэгслийн цуглаан, цахим цуглаан, нэг хүний суулт зэрэг олон арга хэлбэрээр өөрсдийн үзэл бодол, санал, шаардлагыг нийтэд илэрхийлжээ.

Цагдаагийн Ерөнхий Газрын 2021 оны 9 дүгээр сард өгсөн мэдээллээр 2020 онд улсын хэмжээнд 255 жагсаал, цуглаан зохион байгуулагдсанаас нийслэлд 237, орон нутагт 18, 2021 оны 7 дугаар сарын байдлаар 121 жагсаал, цуглаан зохион байгуулагдсан гэжээ.¹¹ (тайлбар: жагсаал, цуглааныг олон нийтийн арга хэмжээнээс зорилго, агуулгын хувьд заагласан эсэх нь эргэлзээтэй тоо бүртгэл).

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед олон хүн оролцсон хурал, уулзалт, наадам, ойн баяр, спортын уралдаан, тэмцээн, шагнал гардуулах болон элдэв нээлтийн үйл ажиллагаа зэрэг олон нийтийн бусад арга хэмжээг бодитоор хүлээн зөвшөөрч, зохион байгуулж байсан хэдий ч халдвар, хамгааллын аюулгүй байдал, хүн хоорондын зайг баримтлан явагдсан тайван жагсаал, цуглаан, цаашлаад нэг хүний суулт, хөдөлмөрийн багаж хэрэгслийн цуглааныг холбогдох засаг, захиргааны нэгжийн Засаг даргад мэдэгдэж бүртгүүлээгүй гэх үндэслэлээр цагдаагийн байгууллагаас албадан тарааж, иргэд, төрийн бус байгууллагад Зөрчлийн тухай хуулиар хариуцлага ногдуулсан нь хүний эрхийн хязгаарлалт үндэслэл бүхий байх, зорилгод хүрэхэд зайлшгүй, гарцаагүй байх шаардлагад нийцэхгүй байхын зэрэгцээ үл ялгаварлах зарчимд харшилж байна.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т “улс орны буюу тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд онц болон дайны байдал зарласан, гамшиг болон аюул тохиолдсон бол тухайн нутаг дэвсгэрт уг шалтгаан арилтал жагсаал, цуглаан хийхийг хориглоно” хэмээн заасан бөгөөд хэрэв гамшгийн үед жагсаал, цуглаан зохион байгуулах тухай мэдэгдлийг иргэн, хуулийн этгээд харьяа нутаг дэвсгэрийн Засаг даргад гаргавал мэдэгдлийг бүртгэхээс татгалзахаар¹² хуульчилсан нь хүний эрхийг өргөн хүрээнд зөрчих нөхцөлийг бүрдүүллээ. Ийнхүү харьяа нутаг дэвсгэрийн Засаг даргад бүртгүүлэлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулсан бол торгуулийн шийтгэл ногдуулахаар Зөрчлийн тухай хуулийн 5.8-д заажээ.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар цар тахлын аюул, эрсдэлийн түвшин зэргээс үл хамааран гамшгийн шалтгаан арилтал жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг тодорхой бус хугацаагаар хязгаарласан нь хүний эрхийг хязгаарлахад баримтлах суурь зарчим болох хүний эрхийг хязгаарлах зорилгод хүрэхэд зайлшгүй байх, тухайн нөхцөл байдалд тохирсон, тодорхой хүрээ, хязгаартай байх шаардлагыг зөрчиж байна.

¹⁰ Эмнести Интернэшнл “Хуран цуглах эрх: НҮБ-ын Хүний Эрхийн Хороонд хүргүүлэх танилцуулга, 125 дахь танилцуулга, 2019 оны 3 дугаар сар.

¹¹ Цагдаагийн Ерөнхий Газрын албан тоот 2021 оны 9 дүгээр сарын 7, 2/333

¹² Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 10 дугаар зүйл

5.1.1 ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨГ ХУУЛЬ БУСААР ХЯЗГААРЛАСАН НЬ

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/930 тоот захирамжаар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд олон нийтийг хамарсан жагсаал, цуглааныг түр зогсоохоор, түүнчлэн иргэн, хуулийн этгээдээс зохион байгуулах олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааныг бүртгэхгүй байхыг Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон дүүргийн засаг дарга нарт даалгажээ.

Мөн Нийслэлийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/25 тоот захирамж, 2021 оны 5 дугаар сарын А/357 тоот захирамжаар олон нийтийг хамарсан хурал, жагсаал, цуглаан зохион байгуулахыг хориглосон байна.

Ковидын хууль, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуульд жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах бүрэн эрхийг Нийслэлийн Засаг даргад олгоогүй. Ийнхүү нийслэлийн Засаг дарга хуулиар олгогдоогүй бүрэн эрхийг хэрэгжүүлж жагсаал, цуглаан зохион байгуулах эрхийг захирамжаар хязгаарлан жагсаал, цуглаан хийх мэдэгдлийг бүртгэхийг хориглосон нь тайван жагсаал, цуглаан зохион байгуулсан иргэнд Зөрчлийн тухай хуулийн 5.8-д заасан жагсаал цуглаан хийх журам зөрчих үйлдэлд хариуцлага ногдуулаад зогсохгүй, мөн хуулийн 5.13 дугаар зүйл Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчсөн үндэслэлээр баривчлах шийтгэл ногдуулах нөхцөлийг бүрдүүлжээ.¹³

2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Баянгол дүүрэгт жижиглэнгийн худалдаа эрхлэгчдийн зарим төлөөлөл Төрийн ордны баруун хойд хаалганы гадна Ерөнхий сайд болон Шадар сайдад шаардлага хүргүүлэхээр цуглажээ. Уг цуглааныг зохион байгуулсан үндэслэлээр иргэн С.М-г цагдаагийн байгууллагаас 1 хоног албадан саатуулжээ. 2021 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн шүүхээс С.М-д Зөрчлийн тухай хуулийн 5.8, 5.13 дахь заалтыг зөрчсөн үндэслэлээр 7 хоног баривчлах шийтгэл ногдуулжээ.¹⁴



© www.mpa.mn. 2021 оны 1 дүгээр сарын 20. Д.Сүхбаатарын талбайд иргэд сайн дураараа нэгдэн Улсын Онцгой комиссыг огцрохыг шаардлаа

Харин Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/930, 2021 оны А/25, А/357 тоот захирамж батлагдахаас өмнө цар тахлын үед эрх бүхий байгууллагад бүртгэлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулсан иргэнд Зөрчлийн тухай хуулийн 5.13-т заасан шийтгэл ногдуулах үндэслэлгүй хэмээн Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн шүүхээс шийдвэрлэж байжээ.

¹³ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 5.8-д эрх бүхий байгууллагад бүртгүүлэлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулсан иргэнд Зөрчлийн тухай хуулиар нэг зуун тавин нэгж буюу 150.000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулах бол Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчиж гамшиг, халдварт өвчний үед эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, дэглэм зөрчсөн үйлдэлд иргэнийг таван зуун нэгж буюу 500.000 төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулахаар Зөрчлийн тухай хуулийн 5.13-т заажээ.

¹⁴ Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Зөрчлийн шийтгэл ногдуулах тухай шийтгэвэр, 2021.01.27, 2021/ЗШ/106

Иргэн “М” нь Сүхбаатарын талбайн цэцэрлэгт хүрээлэнд усан оргилуур барих үйл ажиллагааг эсэргүүцэн тайван жагсаалыг 40 гаруй хоногийн хугацаанд зохион байгуулжээ. Цагдаагийн байгууллагаас түүнийг Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “...эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэм...” зөрчсөн үндэслэлээр 150000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулжээ. 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс “М”-аас гаргасан гомдлоор дээрх зөрчлийн хэргийг хянаад “... эрх бүхий байгууллагаас хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт тогтоосон ямар эрх зүйн акт гарсан эсэх нь тодорхойгүй, ...түүнчлэн эрх бүхий албан тушаалтан шүүхийн хэлэлцүүлэгт Нийслэлийн Засаг даргын захирамжаар олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахыг хязгаарласан байхад цуглаан зохион байгуулж, бөөгнөрөл үүсгэсэн гэж байгаа нь Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хуулийг төсөөтэй хэрэглэхгүй гэсэн хууль ёсны зарчимд нийцэхгүй” хэмээн үзэж шийтгэлийн хуудсыг хүчингүй болгожээ.¹⁵

Түүнчлэн Нийслэлийн Засаг даргын холбогдох шийдвэрээр ямар нэг хорио цээрийн дэглэм, хөдөлгөөний хязгаарлалт тогтоогоогүй, жагсаал, цуглаан хийхийг хориглон хязгаарлаагүй байхад тайван жагсаал, цуглаан зохион байгуулсан иргэдэд Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “... эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн ...” гэх үндэслэлээр хариуцлага ногдуулж байгаа нь хууль хэрэглээний ноцтой гажуудлыг бий болгож байна.

Иргэн А, Б нар нь 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Сүхбаатарын талбайд “Тэвчээр тасарлаа” уриан дор флаш моб хийжээ. Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс тус дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгаас ирүүлсэн зөрчлийн хэргийг хянаад зөрчилд холбогдогч А, Б нар нь Нийслэлийн засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн А/477 дугаар захирамжийг зөрчсөн үндэслэлээр Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 500.000 төгрөгөөр торгох шийтгэл тус тус оногдуулжээ. Гэвч Нийслэлийн засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн А/477 тоот “Коронавируст халдварын (Ковид-19) тархалтыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай” захирамжаар иргэдийн жагсаал, цуглаан зохион байгуулах эрхийг хориглох, хязгаарлах, хорио цээрийн болон хөдөлгөөний хязгаарлалт тогтоогоогүй байна.

5.1.2 ЯЛГАВАРТАЙ ХАНДСАН НЬ

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Засгийн газрын болон орон нутгийн захиргааны байгууллагаас олон хүн цугларсан олон нийтийн арга хэмжээг хүлээн зөвшөөрсөн хэдий ч иргэдийн улс төрийн үндсэн эрх болох тайван жагсаал, цуглаан зохион байгуулах эрхийг хязгаарласан нь хүний эрхийг гарцаагүй тохиолдолд зайлшгүй үндэслэлээр хязгаарлах олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцэхгүй байна.

Олон нийтийн арга хэмжээг зохион байгуулагч нарт Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчсөн үндэслэлээр Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх, эсхүл арга хэмжээг албадан тараах зэрэг арга хэмжээг хууль сахиулах байгууллагаас хэрэгжүүлсэнгүй. Харин хүн хоорондын зай, халдвар хамгааллын дэглэм баримтлан Үндсэн хууль, олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр хамгаалагдсан жагсаал, цуглаан зохион байгуулах эрхээ хэрэгжүүлсэн иргэдэд Жагсаал, цуглаан хийх журам болон Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчсөн үндэслэлээр Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэж байгаа нь илтэд ялгавартай хандаж буй үйлдэл бөгөөд эрх зүйн шударга ёсны зарчимд нийцэхгүй байна.

¹⁵ Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэвэр, Шийтгэлийг хүчингүй болгох тухай, 2020.04.29, 2020/ЗШ/515.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас 2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр буюу гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед “Цахим үндэстэн-2021” арга хэмжээг Үндэсний соёл амралтын хүрээлэнд зохион байгуулжээ. Уг арга хэмжээг үзэхээр олон мянган хүн цугларсан бөгөөд эрүүл мэндийн байгууллагаас зөвлөсөн хүн хоорондын зай болон халдвар хамгааллын дэглэм ноцтой алдагдсан болох нь дүрс бичлэг, гэрэл зурагт¹⁶ авагджээ. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ сэтгүүлчид өгсөн ярилцлагадаа, уг арга хэмжээнд тооцоолж байснаас их хүн ирсэн бөгөөд үүнийг тооцоолоогүй нь зохион байгуулагчдын буруу¹⁷ хэмээн хэлжээ. 2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Ковид 19 цар тахлын халдвар авсан тохиолдлын тоо улсын хэмжээнд 2796, нас баралтын тоо 9 байжээ.¹⁸

2021 оны 2 дугаар сарын байдлаар Нийслэлийн засаг даргын тамгын газарт 32 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах тухай хүсэлт ирүүлснээс 9 нь жагсаал, цуглаан хийхтэй холбоотой байсан бөгөөд эдгээр мэдэгдлийг Нийслэлийн Засаг дарга бүртгэхээс татгалзжээ.¹⁹

Харин Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргад хандан 2020 оны 2 дугаар сараас 2021 оны 1 дүгээр сар хүртэлх хугацаанд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах талаарх иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 2 мэдэгдлийг бүртгэн авсан хэдий ч Монгол үндэстний хүний эрх иргэдийн хяналтын хорооноос Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевизэд шаардлага хүргүүлэх зорилго бүхий жагсаал, цуглаан зохион байгуулах мэдэгдлийг Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 7.1.3-т заасан үндэслэлээр бүртгэхээс татгалзжээ.²⁰ Ийнхүү бүртгэн авсан олон нийтийн арга хэмжээнд олон зуун хүн оролцжээ.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар Нийслэлийн Соёл урлагийн газраас ирүүлсэн Тусгаар тогтнолын талбайд “Миний Улаанбаатар бүжгийн чалленж” түүний зураг авалт хийх тухай мэдэгдлийг 2020 оны 8 дугаар сарын 7-ны өдөр бүртгэжээ. Мөн нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Шинжлэх ухаан үйлдвэрлэл инновацийн газраас ирүүлсэн Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэнд “Creative fall festival” урлагийн наадам зохион байгуулах мэдэгдлийг 2020 оны 9 дүгээр сарын 24-нд бүртгэн авчээ. Дээрх арга хэмжээнд 44 урлан, уран бүтээлч, 800 гаруй хүн оролцсон хэмээн тус арга хэмжээг зохион байгуулагч Geru компани мэдээлжээ.²¹



© www.mpa.mn. 2020 оны 5 дугаар сарын 1. МҮХАҮТ-аас зохион байгуулсан “Ажлын байраа хамгаалъя” цахим жагсаал

¹⁶ Видео: Цахим үндэстэн шоунаас хойш халдвар авсан иргэд улам залуужиж байна, (2021-09-29) <https://isee.mn/n/26364>, <https://www.24tsag.mn/a/197472>

¹⁷ ХХМТГ-ын дарга Б.Болор-Эрдэнэ: Цахим үндэстэн арга хэмжээнд олон хүн цуглуулсан нь миний буруу (2010-11-01), <https://zarig.mn/tpq>

¹⁸ www.covid19.mohs.mn

¹⁹ Мөн тэнд.

²⁰ Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан тоот 2021 оны 1 дүгээр сарын 29, 3/150

²¹ <https://www.facebook.com/geru.mn/videos/973426329736379>

2020 онд Сүхбаатар дүүргийн Засаг даргад иргэн, хуулийн этгээдээс жагсаал, цуглаан болон олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах талаар 49 мэдэгдэл ирүүлснээс 15 мэдэгдлийг бүртгэн авч, 34 мэдэгдлийг бүртгэхээс татгалзсан бол 2021 оны 2 дугаар сарын байдлаар өлсгөлөн зарлах тухай 1 мэдэгдлийг бүртгэхээс татгалзжээ.²² Бүртгэн авсан 15 мэдэгдэл, бүртгэхээс татгалзсан 34 мэдэгдлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон бүртгэхээс татгалзсан үндэслэлийн талаар мэдээлэл хүсэхэд Сүхбаатар дүүргийн тамгын газраас жагсаал, цуглаан хийх мэдэгдэл ирүүлсэн иргэн, байгууллагын хууль ёсны эрхийг хөндөж болзошгүй²³ гэсэн үндэслэлээр мэдээлэл өгөхөөс удаа дараа татгалзан мэдэх эрх, мэдээлэл хайх, олж авах эрх чөлөөг хязгаарлалаа.

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн үед нэг дор олон хүн цугларахыг хориглосон үндэслэлээр Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүний оролцоогүй “Эзнээ хүлээсэн ажлын байрны багаж хэрэгслийн цуглаан”-ыг Спортын төв ордны өмнөх талбайд, “Ажлын байраа хамгаалъя” цахим цуглааныг интернэт орчинд зохион байгуулжээ. Уг цуглаанд иргэд, аж ахуйн нэгжүүд цахим байдлаар нэгдэж, үзэл бодлоо илэрхийлэн оролцжээ. Энэ нь Монгол улсад зохион байгуулагдсан нийгмийн өргөн хүрээг хамарсан томоохон цахим цуглаан юм.

МҮХАҮТ-аас “Эзнээ хүлээсэн багаж хэрэгслийн цуглаан”-ыг зохион байгуулах мэдэгдлийг бүртгүүлэхээр Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газар, Засаг дарга болон Нийслэлийн засаг дарга нарт тус тус хандсан боловч Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоосон, нэг дор олон хүн цугларахыг хориглосон, арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй гэсэн үндэслэлээр цуглааныг бүртгэхээс татгалзжээ.²⁴ Гэвч уг арга хэмжээг зохион байгуулагчид хүний оролцоогүй явагдаж байгаа цуглаан хэмээн үзэж 1000 гаруй багаж хэрэгслийг байршуулан бизнес эрхлэгч аж ахуйн нэгжийн үзэл бодол, шаардлагыг цахим орчинд илэрхийлжээ. Тус цахим цуглаанд 20000 гаруй иргэд, 2000 гаруй аж ахуйн нэгж байгууллага нэгдэж,²⁵ давхардсан тоогоор 19 сая орчим үзэлт, хандалт²⁶ авчээ. Харин Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсээс хөдөлмөрийн багаж хэрэгслийн цуглааныг тараах тухай албан шаардлага ирүүлснийг зохион байгуулагчид хүлээн авч багаж хэрэгслээ хураасан хэдий ч Цагдаагийн байгууллагаас жагсаал зохион байгуулагчдад Зөрчлийн тухай хуулийн дагуу 2 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.

МҮХАҮТ-аас цахим орчинд үзэл санаагаа илэрхийлэн зохион байгуулсан жагсаалыг холбогдох төрийн байгууллага, цагдаагийн байгууллагаас хориглон хязгаарласан, саад учруулсан талаарх мэдээлэл судалгааны явцад олдсонгүй. Харин хүн оролцоогүй зохион байгуулсан багаж хэрэгслийг дэлгэн харуулсан цуглааныг цагдаагийн байгууллагаас тараахыг шаардаж, зохион байгуулагч байгууллагад Зөрчлийн хуулиар торгуулийн шийтгэл ногдуулсан нь цар тахлын үед нийгмийн эрүүл мэндийг хамгаалахын тулд олон хүний бөөгнөрөл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилготой нийцэхгүй байхын зэрэгцээ, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэтрүүлэн хязгаарлаж байна.

Түүнчлэн төрийн байгууллагад хүсэлт, шаардлага хүргүүлэх зорилгоор зохион байгуулсан ганц хүний суулт зэргийг жагсаал, цуглаантай адилтган үзэж зохион байгуулах тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлсэн байх шаардлагыг тавьж цагдаагийн байгууллагаас тараахыг оролдсон нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах хууль ёсны зорилгод нийцэхгүй хууль бус шаардлага болжээ.

²² Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан тоот 2021 оны 2 дугаар сарын 2, 3/156

²³ Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан тоот 2021 оны 2 дугаар сарын 2, 3/156

²⁴ МҮХАҮТ-аас судалгааны багт ирүүлсэн 2021.04.22-ны өдрийн мэдээлэл

²⁵ МҮХАҮТ, Үйл ажиллагааны тайлан 2020 он, 7 дахь нүүр, https://www.mongolchamber.mn/resource/mongolchamber/File/2021/02/17/jmuxziifdsx-q0x7r/Tanhim_2020_Tailan.pdf

²⁶ МҮХАҮТ-аас судалгааны багт ирүүлсэн 2021.04.22-ны өдрийн мэдээлэл

2021 оны 4 дүгээр сард Нийгмийн даатгалын шимтгэлийг 2021 оны 1 дүгээр сараас эхлэн 2 хувиар нэмэгдүүлсэн шийдвэрийг эсэргүүцэн гаргасан шийдвэрээ цуцлахыг шаардан МҮЭХ-ны дэд Ерөнхийлөгч С.Э Сүхбаатарын талбайд 4 хоногийн суулт хийжээ. Тэрээр Коронавируст цар тахлын үеийн зохицуулалт, дэглэмийг сахих зорилгоор ганцаараа суулт хийж байгаагаа нийтэд мэдэгдээд дэмжиж байгаа иргэдийг Сүхбаатарын талбай дээр ирж нэгдэхгүй байхыг мэдэгджээ.²⁷ Тэрээр суулт хийх тухай мэдэгдлээ Сүхбаатар дүүргийн тамгын газарт бичгээр өгөх гэсэн боловч тус байгууллагад ковид бүртгэгдсэн гэх шалтгаанаар мэдэгдлийг хүлээн аваагүй бөгөөд цахимаар хүргүүлсэн мэдэгдэлд хуульд заасан хугацаанд хариу мэдэгдээгүй байна. Гэвч цагдаа нар суулт хийх тухайгаа эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлээгүй гэх үндэслэлээр түүнийг суултаа зогсоохыг шаардаж, тараахыг оролджээ.²⁸

Ганц хүний суулт хэлбэрээр үзэл бодлоо тайван журмаар илэрхийлэх нь жагсаал, цуглааны шинжид илэрхий хамаарахгүй тул энэ тухай мэдэгдлийг Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн байх талаарх цагдаагийн байгууллагын тавьсан шаардлага нь хууль бус юм. Гамшгаас хамгаалах тухай хууль болон УОК, Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр ганц хүний суулт гэх зэрэг арга хэмжээг зохион байгуулахыг хориглоогүй бөгөөд ийнхүү бусдыг нэгдэхгүй байхыг уриалан зохион байгуулсан суултыг албадан зогсоохыг оролдсон нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг илэрхий зөрчиж буй хууль бус үйлдэл юм.

5.1.3 ЖАГСАГЧДЫГ ЭРСДЭЛД ОРУУЛСАН НЬ

Халдвар хамгааллын дэглэм сахиж, хүн хоорондын зайг баримтлан явагдаж байгаа тайван жагсаал, цуглаанд ковидын халдвартай хүн оролцсон үндэслэлээр цагдаагийн алба хаагчид иргэдийг өвлийн хүйтэнд олноор нь саатуулж, тэдний нэр, регистр, оршин суугаа хаяг болон харилцах утасны талаарх мэдээллийг авчээ. Жагсаал, цуглаанд оролцсон иргэдийн талаарх мэдээллийг нийгмийн эрүүл мэндийг хамгаалахаас бусад зорилгоор ашиглахгүй байх баталгаа бүрэн бүрдээгүй нь тэдгээр иргэдийг эрсдэлд орууллаа.

УИХ-ын гишүүн С.Ганбаатар Оюу толгойн асуудлаар байр суурь, шаардлага илэрхийлэн 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 9 цагаас эхлэн Сүхбаатарын талбайд өлсгөлөн зарлажээ. Ковидын халдвартай хүнтэй нэгдүгээр хавьталд орсон 2 хүн энэ цуглаанд оролцсон гэх үндэслэлээр мөн өдрийн үдээс хойш Сүхбаатарын талбай руу орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлан тусгаарлах шугам татан цагдаагийн хамгаалалт тогтоожээ.²⁹ Улмаар тус цуглаанд оролцогчдоос Ковидын шинжилгээ авна гэсэн үндэслэлээр олон цаг байлгасны эцэст гэрийн хаяг, утасны дугаар зэрэг хувийн мэдээллийг нэг бүрчлэн бүртгэн авч, гэрийн тусгаарлалтад 7 хоног байхыг зөвлөн цуглааныг тараажээ. Мөн гэрийн тусгаарлалтад байх хугацаанд ХӨСҮТ-ийн явуулын баг Ковидын шинжилгээ авна хэмээн мэдэгджээ. Харин С.Ганбаатарыг дэмжсэн иргэдийн хувьд энэ нь цуглааныг тараах гэсэн башир арга хэмээн үзсэн.³⁰

Түүнчлэн харилцан эсрэг шаардлага, агуулга, зорилго бүхий жагсаал, цуглааныг нэг газарт давхардуулахгүй байхад орон нутгийн захиргааны болон цагдаагийн байгууллага хамтран ажиллах нь тайван жагсаал, цуглаанд дэмжлэг үзүүлэх төрийн үүрэгт хамаарна. Жагсаал, цуглаанд оролцогчид болон жагсаал эсэргүүцэгчдийг хамгаалахын тулд цагдаагийн алба, хууль сахиулах байгууллагууд хангалттай тооны цагдаа гаргаж, бүх талуудын тайван жагсаал цуглаан хийх эрх, эрх чөлөөг хангах үүрэгтэй бөгөөд ингэхдээ олон нийтийг хянах ширүүн тактик баримтлах эсвэл хэтрүүлэн хүч хэрэглэж мөргөлдөөнийг хурцатгахгүй байх ёстой.³¹

Гэвч 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Үндэсний их баяр наадам хийхийг эсэргүүцсэн иргэд болон наадмын үйл ажиллагааг хойшлуулахыг эсэргүүцсэн морь унасан уяачдын төлөөлөл Сүхбаатарын талбайд нэгэн зэрэг өөрсдийн санал, шаардлагыг илэрхийлэн жагсжээ. Жагсаал,

²⁷ <http://jsee.mn/n/20218>

²⁸ С.Э-тэй хийсэн ярилцлага, мөн Монголын Эмнести Интернэшнл, Нээлттэй нийгэм форумас хамтран 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр зохион байгуулсан “Ковид-19 цар тахлын үеийн хууль сахиулах ажиллагаа: Жагсаал, цуглаан” хэлэлцүүлэг.

²⁹ Төв талбайн жагсаалд батлагдсан тохиолдлын нэгдүгээр хавьтал оролцжээ. <https://ikon.mn/n/23y9>

³⁰ Цугларсан иргэд: Ойрын хавьтал энд байсан гэдэг нь худлаа. Иргэдийг тараах гэсэн башир арга. <https://equur.mn/174686/>

³¹ OSCE-ODIHR, Human Rights Handbook on Policing of Assemblies, n. 30 above, pp. 16-17.

цуглааны үеэр цагдаагийн байгууллага дэг журам, хууль ёсыг сахиулах, зөрчилдөөн үүсэхээс урьдчилан сэргийлж ажилласан хэдий ч харилцан эсрэг шаардлага бүхий жагсагчдын хооронд зарим сөргөлдөөн үүссэн нь дүрс бичлэгт авагджээ.³²

5.1.4 ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ АЛБАДАН ТАРААХДАА ХУУЛЬ ЗӨРЧСӨН НЬ

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль болон Цагдаагийн албаны тухай хуульд жагсаал, цуглааныг албадан тараах үйл ажиллагааг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу холбогдох шатны Засаг даргын албадан тараах шийдвэрийн дагуу цагдаагийн байгууллага хэрэгжүүлэхээр хуульчилсан. Түүнчлэн Цагдаагийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлд цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг албадан тараахын өмнө албадан тараах тухай Засаг даргын шийдвэрийг мэдэгдэж, биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн тохиолдолд авах арга хэмжээг урьдчилан анхааруулна хэмээн заасан.

Хүний эрхийн олон улсын хэм хэмжээний дагуу цагдаагийн байгууллага тайван журмаар явагдаж байгаа жагсаал, цуглааныг зохих байгууллагад мэдэгдэл хүргүүлээгүй, бүртгүүлээгүй гэх зэргээр хууль зөрчсөн үндэслэлээр хүч хэрэглэн тараахаас зайлсхийж, тайван жагсаал, цуглаанд оролцогчдын зарим үйлдлийг хүлцэн тэвчих үүрэгтэй.



© www.mpa.mn. 2021 оны 5 дугаар сарын 5. Ардчилсан намаас Д.Сүхбаатарын талбай дээр өлсгөлөн зарлажээ.

Ялангуяа цар тахлаас урьдчилан сэргийлэх халдвар, хамгааллын аюулгүй байдлаа ханган, хүн хоорондын зайг баримтлан явагдаж байгаа тайван жагсаал, цуглааныг албадан тараах нь коронавируст халдвар тархах эрсдэлийг нэмэгдүүлэх тул зайлшгүй шаардлага үүсээгүй л бол жагсаал, цуглааныг албадан тараах, аливаа хүч хэрэглэхээс зайлсхийх шаардлагатай.

Гэвч цагдаагийн байгууллагаас нөхцөл байдалд хүлээцтэй бус хандаж тайван жагсаал цуглаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгээгүйн зэрэгцээ жагсаал, цуглаанд оролцсон иргэдийг айлган сүрдүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр жагсаал, цуглааныг хүч, албадлага хэрэглэн тараах зэргээр үндэсний болон олон улсын хууль тогтоомжийг ноцтой зөрчлөө.

³² <https://fb.watch/v/CKXxRJAW/>

Цагдаагийн байгууллагаас тайван жагсаал, цуглааныг албадан тараах зайлшгүй шаардлага үүсээгүй, түүнчлэн холбогдох Засаг даргын шийдвэр гараагүй байхад Цагдаагийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйл буюу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаарх цагдаагийн алба хаагчийн шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн тохиолдолд иргэнд албадлага хэрэглэх зохицуулалтыг үндэслэн жагсаал, цуглааныг тарааж байгаа нь Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль болон Цагдаагийн албаны тухай хуулийг зөрчжээ.

2020 оны 7 дугаар сарын 1-ний өдөр “UB Comedy”, “Comedy Lab”-ын залуус Сүхбаатарын талбайд “Миний хөгшчүүл одоо болио” гэх шаардлага бүхий цуглааныг зохион байгуулжээ. Дээрх цуглааныг нэн даруй тараах албан шаардлагыг цагдаагийн байгууллагаас цуглааныг зохион байгуулагчдад уншиж танилцуулсан нь тус цуглааныг зохион байгуулагчийн бэхжүүлсэн дүрс бичлэгт бүрэн авагджээ.³³ Гэвч Сүхбаатар дүүргийн Засаг даргаас цуглааныг албадан тараах захирамж гаргасан эсэхийг танилцуулаагүй. Цуглааныг тараах тухай албан шаардлагыг гаргахдаа Цагдаагийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийг³⁴ үндэслэл болгожээ.³⁵ Тус дүүргийн нутаг дэвсгэрт 2020 оны 2 дугаар сараас 2021 оны 2 дугаар сар хүртэлх хугацаанд зохион байгуулсан аливаа жагсаал, цуглааныг албадан тараах тухай шийдвэрийг тус дүүргийн Засаг дарга гаргаагүй хэмээн Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газраас мэдэгдсэн.³⁶

Цагдаагийн байгууллагаас жагсаал, цуглааныг албадан тараасан тохиолдол байхгүй хэмээн мэдэгдсэн³⁷ хэдий ч тайван жагсаал, цуглааныг зохион байгуулсан, идэвхтэй оролцсон иргэдийг тайлбар, мэдүүлэг авна гэсэн үндэслэлээр хүч хэрэглэн цагдаагийн байгууллагад хүргүүлэн олон цагаар албадан саатуулсан нь жагсаал, цуглаан тарах үр дагаварт хүргэжээ. Ийнхүү цагдаагийн байгууллагаас хуульд заасан журмыг удаа дараа зөрчиж Засаг даргын шийдвэргүйгээр жагсаал, цуглааныг албадан тараасан үйл ажиллагааны үед хууль дээдлэх ёсыг хангуулах чиглэлээр холбогдох төрийн захиргааны байгууллагаас анхааран ажиллаагүй нь Үндсэн хууль, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар хамгаалагдсан тайван жагсаал, цуглаан хийх эрхийг өргөн хүрээнд зөрчих нөхцөлийг бүрдүүлжээ.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан жагсаал, цуглааныг албадан тараах тухай мэдэгдлийг зохион байгуулагчид мэдэгдэж, 2 цагийн дотор тарахыг бичгээр шаардана гэсэн заалт практикт нийтлэг зөрчигдлөө.

2020 оны 7 дугаар сарын 1-ний өдөр “UB Comedy”, “Comedy Lab”-ын залуус Сүхбаатарын талбайд зохион байгуулсан цуглаан, 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр УИХ-ын гишүүн С.Ганбаатар Оюу толгойн асуудлаар байр суурь, шаардлага илэрхийлэн Сүхбаатарын талбайд зарласан өлсгөлөн, 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр иргэн “С.М”-ийн Сүхбаатарын талбайн зүүн хойд хаалганы гадаа зохион байгуулсан хөргөгчтэй цуглаан зэрэг жагсаал, цуглааныг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газраас албадан тараах тухай мэдэгдлийг Цагдаагийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийг удирдлага болгон хүргүүлэхдээ жагсаал цуглааныг 2 цагийн дотор сайн дураар тарах тухай шаардлагыг бичгээр өгөөгүй хууль зөрчсөн үйлдэл нь дүрс бичлэгт авагджээ.

Жагсаал, цуглаанд оролцох эрх чөлөөг цаашид хүндэтгэж хамгаалахын тулд Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль болон бусад холбогдох зохицуулалт, практик нь жагсаал цуглааныг зөв зохистой зохицуулах олон улсын зарчимд нийцэж байгаа эсэхэд иж бүрэн дүн шинжилгээ хийж, эрх зүйн зохицуулалтыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх нь зүйтэй. Ингэхдээ НҮБ-ын Тайван замаар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч болон Шүүхээс гадуур, дур зоргоор цаазлах асуудал хариуцсан Тусгай илтгэгч нарын хамтран боловсруулсан Жагсаал, цуглааныг зохицуулах талаарх зөвлөмж болон уг зөвлөмжийн

³³ <https://www.facebook.com/amartuvshin.dorj/videos/10220817365855546/>

³⁴ Цагдаагийн албаны тухай хууль 23 дугаар зүйлийн 23.1-т “Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчлийг арилгуулах, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх зорилгоор хүн, хуулийн этгээдэд тодорхой үйлдлээс татгалзах, эсхүл үйлдэл хийх шаардлага тавьж болно”, 23.7-д “Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаагийн шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, эсхүл хуулийн дагуу явуулж байгаа ажиллагаанд нь саад учруулсан бол албадан гүйцэтгэж, гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” хэмээн тус тус заасан.

³⁵ <https://www.facebook.com/amartuvshin.dorj/videos/10220817365855546/>

³⁶ Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын албан тоот 2021 оны 3-р сарын 16, 3/335

³⁷ ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга, цагдаагийн хурандаа Н.Лхагвасайхан: Цагдаа нар иргэдийн жагсаал, цуглааныг албадан тараасан удаа байхгүй (2021-12-20), https://gereg.mn/news/71537?fbclid=IwAR0n3gQRnGcF_jtGAZUZ9f-21wiNXpGPH45tQhd9UK2cXQ9RgwqVRNm4Has

хэрэгжилтийг шалгах хуудас (А/НRC/31/66)³⁸-аар жагсаал, цуглааны харилцааг зохицуулж байгаа үндэсний эрх зүйн зохицуулалт, практикт бодитой үнэлгээ шаардлагатай байна. Дээрх шалгах хуудас нь Тусгай илтгэгчдийн боловсруулсан зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 10 бүлэг зарчимд үндэслэсэн 100 шалгуур үзүүлэлттэй бөгөөд улс орнууд өөрийн зохицуулалт, үйл ажиллагааг 100 хүртэл оноогоор үнэлэх боломжтой.

Бидний хийсэн урьдчилсан үнэлгээгээр жагсаал, цуглааныг зохицуулж байгаа хууль тогтоомж нь хоёрдмол салаа утгагүй, өөр хоорондоо нийцсэн байх; хуран цуглах эрх чөлөөний асуудлаарх олон улсын хэм хэмжээг хэрэгжүүлэх Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх; жагсаал, цуглааны мэдэгдэл хүлээн авах, хариу өгөх эрх, үүрэг бүхий байгууллага нь хөндлөнгийн нөлөөллөөс хараат бус бөгөөд хэт их эрх мэдэлгүй байх; тайван жагсаал хийх эрхийг эдлэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хүчирхийлэл гарч болзошгүй нь илт байгаагаас бусад тохиолдолд жагсаал, цуглаанд оролцохоор явж байгаа хүмүүсийг замд нь зогсоож, нэгжих, баривчлахгүй байх; төрөөс хүч хэрэглэхэд тавих, мэдээлэх үр дүнтэй тогтолцоог бий болгох; хүний эрхэд суурилсан жагсаал, цуглааныг хүч хэрэглэн тараах удирдамжийг боловсруулж, хэрэгжүүлэх; хүч албадлага хэрэглэсэн талаарх статистик мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах; жагсаал, цуглааныг ажиглах, дүн шинжилгээ хийх; жагсаал, цуглаантай холбоотойгоор хувь хүний мэдээллийг цуглуулах нь хувийн нууц болон бусад эрхэд сөргөөр нөлөөлөхгүй байх баталгааг хангах; төрөөс жагсаал, цуглааны талаарх мэдээллийн нээлттэй ил, тод байдлыг хангах зэрэг үзүүлэлтүүд ерөнхийдөө хангалтгүй байна.

5.2 ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ АЖИЛЛАГАА



Хүний эрхийг харьцангуй бага зөрчих бусад арга хэрэгслийг ашиглах нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгыг хэрэгжүүлэхэд үр дүнгүй, эсхүл хэрэгжих боломжгүй тохиолдолд баривчлах, цагдан хорих зэрэг таслан сэргийлэх арга хэмжээг эцсийн арга хэрэгсэл болгон ашиглах ёстой. НҮБ-ын Хүний эрхийн хороо “зүй зохисгүй, хуульд нийцээгүй, урьдчилан сануулаагүй, зайлшгүй бус, хэр хэмжээнээс хэтэрсэн байх”

зэрэг шинжийг агуулсан цагдан хорих ажиллагааг үндэслэлгүй цагдан хорилт хэмээн үздэг³⁹ болохыг цар тахлын үед анхаарвал зохино. Ялангуяа баривчлах, цагдан хорих арга хэмжээ цар тахлын үед авч хэрэгжүүлэх нь халдвар тархах эрсдэлийг улам бүр нэмэгдүүлдэг.

НҮБ-ын Хүний Эрхийн Хороо, Ерөнхий Тайлбар 35: 9 дүгээр зүйл (CCPR/C/GC/35)

Ковид 19 цар тахлын үед тайван жагсаал, цуглааныг зохион байгуулагч, идэвхтэй оролцогч, эсхүл үзэл бодлоо илэрхийлсэн зарим иргэдийг тайлбар, мэдүүлэг авна гэх үндэслэлээр хүч хэрэглэн саатуулж, цагдаагийн хэлтэст олон цагаар байлгасны зэрэгцээ хууль зүйн туслалцаа авах, өмгөөлөгчийн хамт тайлбар, мэдүүлэг өгөх эрхийг нь ноцтой зөрчжээ.

2021 оны 6 дугаар сарын 25-ны өдөр шинээр сонгогдсон Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын үеэр С.Зориг агсаны хөшөөний өмнө цөөн тооны иргэд цар тахлын эсрэг хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэрийг эсэргүүцэн цуглаан зохион байгуулжээ. Цуглаанд оролцогчид шаардлага бүхий самбар гартаа барин төв зам дагуу зогсохыг хүссэн ч цагдаа нар бүслэлт тогтоон тэднийг олон нийтэд харагдах орчин хязгаарлагдмал орчинд байлгажээ. Цуглааны үеэр иргэн “М” төв зам дагуу шаардлагаа барин зогсохоор оролдох үед цагдаа нар түүнийг машинд хүчээр суулган⁴⁰ цагдаагийн хэлтэст аваачин олон цаг байлгасны эцэст тайлбар авсаны дараа суллан явуулжээ.

Мөн өдөр иргэн “А” нь Сүхбаатарын талбайд Ерөнхийлөгчийн тангараг өргөх арга хэмжээг зохион байгуулж байгааг эсэргүүцэн “халдвар, хамгааллын дэглэмээ зөрчихөө больё, өдөрт олон арван хүн үхэж байхад арга хэмжээгээ зогсоо” хэмээн орилжээ. Хэсэг хугацааны дараа цагдаа нар түүнийг хүч хэрэглэн цагдаагийн хэлтэст аваачин тайлбар, мэдүүлэг авсаны дараа суллан явуулжээ.

³⁸ <https://www.amnesty.mn/index.php/component/content/article/157-resources/online-news/2019-01-02-18-41-40/726-10?Itemid=596>

³⁹ UN Human Rights Committee, General Comment 35: Article 9 (Liberty and security of person), (CCPR/C/GC/35)

⁴⁰ https://www.facebook.com/watch/?ref=search&v=551435479359942&external_log_id=257d66a3-30fe-4ac5-a236-b1fbd93311ed&q=%D0%B-C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB%D1%85%D2%AF%D2%AF%D0%B3

Тайван жагсаал, цуглаанд оролцсон, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн иргэнийг тайлбар, мэдүүлэг авах зорилгоор хүч хэрэглэн албадан саатуулах эрхийг цагдаагийн байгууллагад хуулиар олгоогүй хэдий ч Цагдаагийн албаны тухай хуулийн зарим заалтыг буруугаар тайлбарлан хүний халдашгүй байх эрхэд халдах практик нийтлэг болох эрсдэлтэй байна. Иймд тайван журмаар жагсаал, цуглаан зохион байгуулсан, хуулийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлсэн иргэдийг зүй бусаар албадан саатуулахгүй байх эрхийн баталгааг хуульчлан баталгаажуулах шаардлагатай.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд заасны дагуу жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлээ дүүргийн Засаг даргад бүртгүүлээгүй, түүнчлэн Гамшгийн үед эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, дэглэм зөрчсөн гэх үндэслэлээр тайван замаар жагсаал, цуглаан зохион байгуулсан иргэдийг албадан саатуулж байгаа нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг нухчин дарахын зэрэгцээ цар тахлын эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

Олон улсын хүний эрхийн өдөр буюу 2020 оны 12 дугаар сарын 10-нд МҮОНРТ-ийн хэсэг уран бүтээлчид МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн зарим гишүүдийг УИХ-аар томилох гэж байгааг эсэргүүцэн үзэл бодлоо илэрхийлэн цуглаан зохион байгуулсныг цагдаагийн байгууллагаас албадан тарааж, тус цуглааныг зохион байгуулагч зарим иргэдийг цагдаагийн машинд хүчээр суулгах, жагсаал, цуглаанд оролцогчдын барьсан гэрийг буулгах явцад цагдаа, иргэдийн хооронд сөргөлдөөн үүсэж Ковид цар тахлын үеийн халдвар, хамгааллын дэглэм ноцтой зөрчигдөж байгаа нь дүрс бичлэгт авагджээ.⁴¹ Мөн 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Сүхбаатарын талбайд 20 орчим хүн жагсаал, цуглаан зохион байгуулжээ. Тэдгээр иргэд Ерөнхий сайдад хандан ... үйл ажиллагаа бүрэн зогссон тул зээл, зээлийн хүүг төлөх ямар ч боломжгүй байна. ... зээлийн хүүг царцаах, ... төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэхийг шаарджээ. Харин цагдаагийн байгууллагаас тэдгээр иргэдийг жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлээ бүртгүүлээгүй гэсэн үндэслэлээр дүүргийн Засаг даргын жагсаал, цуглааныг тараах шийдвэр гараагүй байхад тарахыг шаардаж, эцэст нь жагсаал, цуглааныг зохион байгуулахад идэвхтэй оролцсон иргэн "М"-д хүч хэрэглэж цагдаагийн газар руу авч явжээ. Улмаар түүнийг нэг хоног албадан саатуулсны зэрэгцээ, Зөрчлийн тухай хуулийн 5.8, 5.13 дахь заалтыг зөрчсөн үндэслэлээр 7 хоног баривчлах шийтгэл ногдуулах талаарх цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс түүнд баривчлах шийтгэл ногдуулсан байна.

Ийнхүү тайван жагсаал, цуглаан зохион байгуулж, үзэл бодлоо илэрхийлсэн иргэдийг цар тахал тархах өндөр эрсдэлтэй үед баривчлах шийтгэл ногдуулсан нь цар тахлын үед баривчлах болон хорих ял, шийтгэл ногдуулахаас аль болох зайлсхийх талаарх олон улсын санаачлагад⁴² нийцэхгүй байна.

⁴¹ М.Төгөлдөр, Үндэсний телевизийн сэтгүүлч, дууны найруулагч нарын гурван хүнийг цагдаагийн байгууллагаас баривчилаа. (2020.12.10) <https://zarig.mn/o3b2fbclid=IwAR3lPSUdDM5cDtED0TpzruKkkjDVINeg06f0kgHaMQq74SjXvuHyVTAT46s>

⁴² UNODC, WHO, UNAID and OHCHR joint statement on COVID-19 in prison and other closed settings (13.May.2020), <https://www.who.int/news/item/13-05-2020-unodc-who-unaid-and-ohchr-joint-statement-on-covid-19-in-prisons-and-other-closed-settings>

5.3 ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙГ ТАНИХ, ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ БАЙДАЛ



Хууль зүйн үндэслэл бүрдээгүй байхад хэнийг ч баривчилж болохгүй бөгөөд баривчлах ажиллагааг гагцхүү хуульд заасан ёс журмын дагуу гүйцэтгэнэ. Үүнд:

- Цагдаагийн ажилтан болон бусад албан тушаалтнууд баривчлах ажиллагаа явуулахдаа өөрсдийн таних тэмдгийг тодоор гаргасан дүрэмт хувцас өмссөн байвал зохино. Бусад таних тэмдэг болох үнэмлэх зэрэг бүх зүйлийг үзүүлнэ.
- Баривчлагсад болон саатуулагчдыг зөөх цагдаагийн болон цэргийн бүхээгт машин нь мөн таних тэмдгээ тодруулах ёстой.

НҮБ-ын Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчим /Зарчим 12/

Олон нийт, иргэдтэй харилцаж байгаа хууль сахиулах байгууллагын алба хаагч нь өөрийн хэрэгжүүлсэн үйлдэл, үйл ажиллагааныхаа хариуцлагыг бүрэн хүлээхийн тулд таних тэмдэг бүхий дүрэмт хувцас өмсөж, үнэмлэх зэрэг хууль ёсны бүрэн эрхтэй болох бичиг баримтыг үзүүлэх шаардлагатай. Түүнчлэн баривчлагдсан хүмүүсийг зөөх цагдаагийн машин нь таних тэмдэгтэй байвал зохино.

Гэвч үзэл бодлоо илэрхийлсэн, тайван жагсаал, цуглаан хийсэн иргэнийг баривчилсан цагдаагийн алба хаагчид нь таних тэмдэг бүхий дүрэмт хувцас өмсөөгүй, цагдаагийн үнэмлэхээ уншигдахуйц байдлаар үзүүлээгүй, түүнчлэн зөөн тээвэрлэсэн машин нь тусгайлсан таних тэмдэггүй байсан нь хүний эрхийн ноцтой зөрчил үүсэх эрсдэлийг бий болгож байна.

2021 оны 6 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөсөн цуглаанд оролцох гэж байсан иргэн "О"-г цагдаагийн нэр, таних тэмдэг бүхий дүрэмт хувцас өмсөөгүй цагдаагийн алба хаагчид хүч хэрэглэн баривчилж, тусгайлсан таних тэмдэггүй машинд суулгаж байгаа бичлэг цахим орчинд цацагджээ.^{43, 44}



© www.itoim.mn 2021 оны 6 дугаар сарын 25-нд нийтлэгдсэн "ВИДЕО: Үзэл бодлоо илэрхийлэх гэсэн Э.Одбаярыг цагдаа нар дайчлан баривчилж, авч явжээ" мэдээний зураг

⁴³ https://www.facebook.com/watch/?ref=search&v=941546029961427&external_log_id=3dcb5f1a-ea4b-42e8-8aa3-210ff396a-c6a&q=%D0%BE%D0%B4%D0%B1%D0%B0%D1%8F%D1%80%D1%8B%D0%B3%20%D0%B1%D0%B0%D1%80%D0%B8%D0%B2%D1%87%D0%BB%D0%BB%D0%B6%D1%8D%D1%8D

⁴⁴ <http://itoim.mn/article/0XSMn/28325>

5.4 ЭСЭРГҮҮЦЭЛ, ШҮҮМЖЛЭЛИЙГ НҮХЧИН ДАРСАН НЬ



Улс орнууд Ковид-19 цар тахлын хүрээнд иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлахдаа ч мөн нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, эсхүл холбогдох бусад хууль ёсны зорилготой, онцгой байдлын үед тохирсон, зайлшгүй байх зарчмыг харгалзан үзсэн тодорхой урьдач нөхцөл бүхий хуулийн заалтын дагуу олон улсын хүний эрхийн хууль, эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлсэн байх шаардлагатай.

“Хуурамч мэдээ”, “ташаа мэдээ мэдээлэл” гэх зэрэг тодорхойгүй, хоёрдмол утга агуулсан мэдээлэл тараахыг бүхэлд нь хориглох явдал нь энд дурдсан шалгуурт тэнцэхгүй тул үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй нийцэхгүй гэж үзэхээр байна. Бүхэлд нь хориглох арга хэмжээ нь хүн ам, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хэт хүнд тусах эрсдэлтэй бөгөөд тэднийг хуулийн хариуцлага хүлээхээс эмээж өөрсдийн дуу хоолойг дарж, бодлоо илэрхийлэхээс өөрөө өөрийгөө хорих сөрөг нөхцөл байдалд хүргэх юм. Олон улсын эрх зүйгээр санал бодлоо алдаатай илэрхийлэх, эсхүл үйл явдлыг буруу ташаа тайлбарлах зэргийг ерөнхийлөн хориглохыг зөвшөөрдөггүй байна.⁴⁵

Хүний Эрхийн Хороо, Ерөнхий Тайлбар No. 34, 19 дүгээр зүйл: Үзэл санаа, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө 49 дүгээр параграф

Сэтгүүлч, хүний эрх хамгаалагч, цахим орчин, нийгмийн сүлжээний хэрэглэгч болон жирийн иргэдийг засгийн газраас хэрэгжүүлж буй цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний талаар үзэл бодлоо илэрхийлж, шүүмжилснийх нь төлөө хэрэг үүсгэн шалгах, баривчлах, цагдан хорих зэргээр Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактаар хамгаалагдсан халдашгүй чөлөөтэй байх эрх, эвлэлдэн нэгдэх зэрэг хүний үндсэн эрхийг ноцтой зөрчиж байна.

2021 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн эрүүл мэндийн салбарын эмч, ажилчдын төлөөлөл үндсэн цалингаа улсын дундаж цалин хөлстэй дүйцүүлэхийг Засгийн газраас шаардаж Сүхбаатарын талбайд 8 хоног суулт хийжээ. Суулт хийсний үр дүнд Үйлвэрчний Эвлэлүүдийн Холбоо Засгийн газартай 3 үндсэн асуудлаар тохиролцоонд хүрч гэрээ, хэлцлийг зохих журмын дагуу баталгаажуулсан боловч Засгийн газар гэрээгээр хүлээсэн үүргээ бодитоор, зохих ёсоор гүйцэтгээгүй байна. 2021 оны 9 дүгээр сарын 1-нд Монголын Эрүүл Мэндийн Ажилтны Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбооны (МЭМАҮЭХ) тэргүүлэгчид эмч, эмнэлгийн ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх үүргээ Засгийн газар биелүүлээгүй асуудлаар авч хэрэгжүүлэх дараагийн үйл ажиллагааны талаар хэлэлцжээ. Гэвч уг хуралд суусан иргэн “С” нь МЭМАҮЭХ-ны гишүүдийн нэрийг бичиж тэдний хурлаар хэлэлцсэн асуудлын талаар Ерөнхий сайдад хандан гомдол гаргажээ. Гомдлыг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт цохож Хууль зүй, дотоод хэргийн сайдад, ХЗДХ-ийн сайдаас Цагдаагийн Ерөнхий Газрын даргад, улмаар Эрүүгийн цагдаа, Нийслэлийн прокурор, эцэст нь Тагнуулын Ерөнхий Газарт шилжсэн байна. Улмаар Тагнуулын Ерөнхий Газраас МЭМАҮЭХ-ны нэр бүхий төлөөлөгчдийг гэрчээр дуудаж тайлбар, мэдүүлэг авчээ.^{46, 47} МЭМАҮЭХ-ны тэргүүлэгчид цаашид гишүүдийнхээ эрхийг хуулийн хүрээнд тууштай хамгаалах, эвлэлдэн нэгдэх эрхээ хараат бусаар чөлөөтэй хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болж айдаст автаж байгаагаа илэрхийллээ.

Иргэдээс өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэн телевиз, сайт зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгсөн үйлдлийг хууль зөрчин зохион байгуулсан жагсаал, цуглаан хэмээн үзэж зөрчлийн хэрэг нээх, түүнчлэн зөрчилд холбогдогч иргэнд зөрчлийн хэрэг нээхгүйгээр шийтгэл ногдуулах зэргээр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчлөө.

2020 оны 12 дугаар сарын 1-ний өдөр нэгэн ТББ-ын тэргүүн “Э” болон иргэн “О” нар Нарантуул олон улсын худалдааны төвийн өмнө “Paparazzi.mn”, “Zarig.mn” зэрэг сайтын сэтгүүлчдэд цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэл, бэрхшээлийн талаар ярилцлага өгчээ. Гэвч цагдаагийн байгууллагаас тэдгээр иргэдийг эрх бүхий байгууллагад мэдэгдлээ бүртгүүлэхгүйгээр хууль зөрчин жагсаал, цуглаан явуулсан хэмээн үзэж Зөрчлийн тухай хуулийн 5.8, 5.13 дахь заалтыг зөрчсөн үндэслэлээр шийтгэл ногдуулах хүсэлтийг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн

⁴⁵ Human Rights Committee, General Comment No. 34, Article 19: Freedoms of opinion and expression, UN Doc. CCPR/C/GC/34 (2011), para. 49.

⁴⁶ Ө.Анхболд, Ажил хаялын талаар хэлэлцсэний дараа биднийг Тагнуулын Ерөнхий Газраас дуудаж байцаасан (2021.11.13). https://isee.mn/n/280702fbclid=IwAR38wZTbwdHH7EqsZ_04NRRrcF4n0cJaWU9LvtAhgaC_4F_bCkRhJhXF08

⁴⁷ “Ярих өнцөг” ярилцлагын нэвтрүүлэг, https://www.facebook.com/watch/live/?ref=watch_permalink&v=852553575364904

анхан шатны шүүхэд ханджээ.⁴⁸ 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр шүүхээс зөрчлийн хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр цагдаагийн байгууллагад буцаажээ. Улмаар 8 сарын дараа буюу 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн шүүх хуралдаанаар иргэн “Э”, “О” нар хууль зөрчин жагсаал, цуглаан явуулсан гэдэг нь нотлогдоогүй гэх үндэслэлээр шүүхээс зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. Шүүх шийдвэртээ эрх бүхий албан тушаалтан нь иргэн “О”-д холбогдуулан зөрчлийн хэрэг нээхгүйгээр зөрчлийн хэрэгт холбогдуулан шалгаж шийтгэл ногдуулах санал хүргүүлсэн нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөнийг дурджээ.⁴⁹

Ковид цар тахлын үед төрөөс Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах, Зөрчлийн тухай хуулийн 5.8 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих, 5.9 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих, 5.13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих зэрэг зохицуулалтыг иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, шүүмжлэлт дуу хоолойг нухчин дарах хэрэгсэл болгон ашиглаж байна.

Эрүүгийн хуулийн 13.14 дэх зүйлд Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хуульчлахдаа гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын элементийг тухайлан заагаагүй, илт худал мэдээлэл гэдгийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байгаа нь хуулийг янз бүрээр тайлбарлан хэрэглэж иргэдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, цахим мэдээлэлд сэтгэгдэлд бичсэн доромж, бүдүүлэг үг хэллэгийг “илт худал мэдээлэл тараасан” гэмт хэрэг хэмээн үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа нь эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх зарчимд нийцэхгүй бөгөөд хуулийг буруу ойлгон хэрэглэх практикийг бий болгож байна.

Хүний нэр хүнд хуулиар хамгаалагдах нь гарцаагүй хэдий ч нийтийн өндөр албан тушаалтнууд, тэр дундаа улс төрчдийн нэр төр, алдар хүндийн хамгаалалтад нийгмийн гишүүдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэх боломжийг хангах зорилгоор зарим хязгаар тогтоодог.⁵⁰ Учир нь хүн бүр нийгэм, эдийн засаг, улс төр амьдралын тодорхой асуудал, улс төрийн албан тушаалтнуудын шийдвэр, үйл ажиллагаа, хэлсэн үг, үйлдэл, хэрэгжүүлсэн бодлого, түүний үр нөлөө, үр дагаврын талаар иргэн өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх, нийтийн мэтгэлцээн, хэлэлцүүлгийг саадгүй, өргөн хүрээнд хэрэгжүүлэх боломж, нөхцөл нээлттэй байх шаардлагатай.

Түүнчлэн жирийн иргэн нийгмийн тодорхой асуудлаар байр суурь, үзэл бодлоо илэрхийлэхдээ мэдээллийн үнэн зөвийг заавал нягтлан шалгах үүрэггүй бөгөөд алдаа гаргаж болохыг НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос гаргасан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын Ерөнхий санал, зөвлөмж №34-т “... олны танил хүмүүсийн талаарх сэтгэгдлүүдийн хувьд алдаатай боловч хорон санаагүйгээр нийтэлсэн хууль бус худал мэдээлэлд ял шийтгэл ногдуулахаас зайлсхийх шаардлагатай” хэмээн тайлбарласан.

Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааг шүүмжлэн цахим орчинд үзэл бодлоо илэрхийлсэн иргэдийг үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлгүй хандсан үндэслэлээр Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйл Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчсөн хэмээн үзэж торгуулийн шийтгэл ногдуулах байдал цөөнгүй гарч байна. Харин Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйлийг шүүхээс харилцан адилгүй ойлгон хэрэглэж байгаа нь хүний эрх зөрчигдөх нөхцөлийг улам нэмэгдүүлж байна.

Иргэн “О” өөрийн цахим хуудсандаа “... Женко огцор, Монгол Улсын хөгжлийг гацааж төмөр замын ажлыг овоолсон шороо болгосон гэмт хэрэгтэн нэн даруй огцор”, “Путины гар, хөл бол гэж Ерөнхийлөгч болоогүй”, “Жонхуу чинь хаан болчихсон юм уу. Засгийн газар түүний гишүүдийг дуудаж загнадаг. Шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдалд халдаж Үндсэн хууль зөрчсөн чинь үнэн ш дээ. Хэлмэгдүүлэлт хийж улс төрийн хоригдлууд бий болгосон чинь ч үнэн” зэргээр нийтэлжээ. Ерөнхийлөгчийн Тамгын газраас ирүүлсэн гомдлыг үндэслэн цагдаагийн байгууллагаас дээрх үйлдэлд зөрчлийн хэрэг үүсгэн шалгаад иргэн “О” нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэх заалтад заасан “бусдын нэр төр, алдар хүнд, эрх хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй байх, өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах

⁴⁸ Зөрчлийн хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж, 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр, 2021/ШЗЗ/02

⁴⁹ Зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж, 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдөр, 2021/ШЗ/1575.

⁵⁰ Council of Europe, Defamation and Freedom of Expression, (2003 Strasbourg), 26. <https://rm.coe.int/1680483b2d>

....” үүрэгтэй гэснийг зөрчсөн хэмээн үзэж Зөрчлийн тухай хуулийн 5.9-д зааснаар 100,000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулжээ. Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс иргэн О-ын гаргасан гомдлыг хэлэлцээд түүний цахим орчинд нийтэлсэн мэдээлэл нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан иргэний эрхэд халдаж байгаа үйлдэл бөгөөд хуулийн дагуу шүүхээр гэм буруутай нь тогтоогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэхгүй гэснийг зөрчсөн тул гомдлыг хангахгүй хэмээн шийдвэрлэжээ.⁵¹

Мөн иргэн “О”-д 2021 оны 6, 7 дугаар сард өөрийн цахим хаягнаас нийтдээ 16 удаа бусдын нэр хүндэд хүндэтгэлгүй хандсан мэдээллийг тараасан хэмээн цагдаагийн байгууллагаас түүнд Зөрчлийн тухай хуулийн 5.9-д заасан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчсөн гэх үндэслэлээр торгуулийн шийтгэл ногдуулжээ. Иргэн “О”-ийн шийтгэлийг эс зөвшөөрч гаргасан гомдлоор Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шийтгэлийн хуудсыг хянаад Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэх хэсгийн заалт нь уг хуулийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын бүрэн эрх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцогчийн эрх, үүргийг хуульчилсан заалт байх тул дээрх заалт нь иргэн “О”-д хамаарахгүй, тэрээр “үүрэг хүлээсэн субъект” гэж үзэх боломжгүй гэсэн үндэслэлээр гомдлыг хангаж шийтгэлийн хуудсыг хүчингүй болгож шийдвэрлэсэн нь шүүхээс хуулийн заалтыг харилцан адилгүй ойлгож тайлбарлаж байгааг харуулж байна.

Үзэл бодлоо илэрхийлсэн, тайван жагсаал, цуглаан зохион байгуулсан иргэдийг зөрчлийн хэрэгт холбогдуулан шалгах, шийтгэл оногдуулахдаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан хугацааг зөрчин зөрчлийн хэргийг эцэслэн шийдвэрлэхгүй олон сар болж байгаа нь гэм буруугийн асуудлаа боломжит богино хугацаанд шийдвэрлүүлэх эрх буюу шударгаар шүүлгэх эрхийг зөрчиж байна. Ялангуяа, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.2 дугаар зүйлийн 9.2.5 дахь хэсэгт заасан шүүгч нэмэлт нотлох баримт гаргуулах тухай талуудын хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг 14 хүртэлх хоногоор завсарлуулж, хэрэг бүртгэлийн нэмэлт ажиллагаа хийлгүүлэхээр цагдаагийн байгууллагад даалгаж болно хэмээн заасан хэдий ч дээрх хугацааг олон сараар үндэслэлгүйгээр хэтрүүлж байгаа тохиолдол цөөнгүй байна.

“Э” болон иргэн “О” нарт холбогдох Зөрчлийн тухай хуулийн 5.8, 5.13 дугаар зүйлийг зөрчсөн талаарх хэргийг 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хэргийг хэлэлцээд шүүх хуралдааныг 14 хоногоор завсарлуулж зөрчлийн хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр цагдаагийн байгууллагад даалгаж буцаажээ. Гэвч завсарласан хуралдааныг найман сарын дараа буюу 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдөр үргэлжлүүлж “Э”, “О” нарт оногдуулсан шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосон байна.⁵²

Түүнчлэн 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдөр Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс иргэн “А”, “Б” нарын Сүхбаатарын талбайд флаш моб арга хэмжээ зохион байгуулсан үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 5.8, 5.13 дугаар зүйлийг зөрчсөн үндэслэлээр цагдаагийн байгууллагаас торгуулийн шийтгэл ногдуулсан нь үндэслэлтэй эсэхийг иргэдийн гаргасан гомдлоор хэлэлцээд нэмэлт ажиллагаа хийх үүргийг цагдаагийн байгууллагад даалган шүүх хуралдааныг 14 хоногоор завсарлуулжээ. Гэвч дараагийн шүүх хуралдаан 4 сар орчим хугацааны дараа буюу 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр болж улмаар иргэн “А”, “Б” нарын гаргасан гомдлыг хангахаас татгалзаж, шийтгэлийн хуудсыг хэвээр үлдээжээ. Харин 2022 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс дээрх шүүхийн шийдвэрийг хянаад хууль зөрчсөн үндэслэлээр хүчингүй болгож, иргэдэд оногдуулсан торгуулийн шийтгэлийг хүчингүй болгожээ.

⁵¹ Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэвэр, 2021 оны 06 сарын 29, дугаар 2021/ЗШ/587

⁵² Судалгааны багийн өмгөөлөгч нартай хийсэн уулзалтын тэмдэглэл

5.5 ЦАГДААГИЙН ХҮЧ АЛБАДЛАГЫГ ХЭТРҮҮЛЭН ХЭРЭГЛЭСЭН НЬ



Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнууд нь гарцаагүй тохиолдолд л үүргээ биелүүлэхийн тулд хүч хэрэглэж болох ч тавьсан шаардлагадаа хүрэхэд хэтэрсэн хүч хэрэглэхгүй байхаар бодож хүчийг хязгаарлана. Бусад бүх арга хэмжээ нь ямар ч үр дүнд хүрээгүй буюу ашиггүй, үр дүнд хүрэх найдлагагүй болсон нөхцөлд л хүч хэрэглэж болно. Хууль ёсны хүч хэрэглэх нь зайлшгүй болсон нөхцөлд цагдаагийн ажилтан нь:

- Зөрчлийн гарч болох хүнд хөнгөн үр дагаварыг нарийн тооцож хүлээцтэй хандах
- Хүний аминд хүрэхгүй, хүнийг хамгаалах үүднээс хандаж аль болох бага хохирол, шарх үүсгэх
- Шархадсан буюу бусад байдлаар хохирсон этгээдэд аль болох яаралтай эмнэлгийн тусламж үзүүлэх, тийм баталгааг хангах
- Шархадсан буюу бусад байдлаар хохирсон этгээдийн найз нөхөд, төрөл садан, эцэг эхэд нь энэ талаар аль болох түргэн шуурхай мэдээлэх боломжоор хангах
- Цагдаагийн ажилтан хүч хэрэглэсний улмаас ноцтой шархадсан буюу амь нас нь хохирсон бол энэ тухайгаа дээд шатны албан тушаалтандаа нэн даруй мэдээлнэ.

НҮБ-ын Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль /З-р зүйл/, НҮБ-ын Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчмууд /зарчим 4, 5, 6, 9/

Олон нийтийн жагсаал, цуглааныг албадан тараасан, иргэдийг үндэслэлгүйгээр баривчилсан, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах хорио цээрийн дэглэмийг зөрчсөн хүмүүст таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа эрсдэлд оруулсан, ялгаварлан гадуурхсан, хүч хэтрүүлэн хэрэглэсэн, хүнлэг бус харьцсан цөөнгүй тохиолдлыг Монголын Эмнести Интернэшнл баримтжууллаа.

Цар тахлын онцгой нөхцөл байдал нь цагдаагийн алба хаагч үйл ажиллагаандаа үндэсний хууль тогтоомж, олон улсын хэм хэмжээг мөрдөхгүй байх үндэслэл болохгүй. Хууль сахиулагчид нь зөвхөн зайлшгүй шаардлагатай тохиолдолд хүч, албадлагыг тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх бөгөөд ингэхдээ үл ялгаварлах, хүний эрхийн хязгаарлалтыг дур мэдэн хэрэгжүүлэхгүй байх зарчмыг баримтална.⁵³

Цагдаагийн алба хаагч цар тахлын үед Ковидын хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх зэргээр нэмэлт чиг үүргийг хэрэгжүүлж байгаа хэдий ч Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд тэдгээр чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлэх журам, процессыг нарийвчлан зааж өгөөгүй нь хүний эрх зөрчигдөх нөхцөлийг бий болгож байна.

Түүнчлэн төрийн холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар тодорхой биш, мэдээллийн солилцоо хэт удаашралтай зэрэг нь цагдаа, иргэдийн хооронд үл ойлголцол үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна.⁵⁴ Гэвч цагдаагийн алба хаагчийн хууль, хүний эрхийн мэдлэг, хандлага хангалтгүй, ёс зүй, харилцааны доголдол нь хүний эрх зөрчигдөх шалтгаан болж байна.

Цар тахлын үед цагдаагийн байгууллагаас нийтийн хэв журам хамгаалах зорилгоор олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн талаарх мэдээлэл манай улсад олдсонгүй. Харин Цар тахлын үед цагдаагийн алба хаагч чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүч, албадлагыг хэтрүүлэн хэрэглэсэн талаарх дараахь зарим тохиолдлыг баримтжууллаа.

5.5.1 ЯЛГАВАРЛАН ГАДУУРХСАН НЬ

Цагдаагийн байгууллагаас хууль сахиулах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ цар тахлын үеийн хөл хорионы болон хязгаарлалтын дэглэм зөрчсөн үйлдэлд холбогдсон зарим иргэдийн хувийн мэдээллийг олон нийтэд мэдээлж, тэднийг нийгмийн зүгээс алагчлах, нэр төрийг нь гутаан доромжлох нөхцөлийг бүрдүүлжээ.

⁵³ НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газраас 2020 оны 04 дүгээр сард гаргасан "Онц байдал ба Ковид-19" удирдамж

⁵⁴ Нээлттэй нийгэм форум, "Цагдаагийн байгууллага, албан хаагч Бүх нийтийн бэлэн байдлын үед мөрдөж ажиллах хууль, дүрэм, журмын хэрэгжиж буй байдал" судалгааны тайлан, 2020, 19 дэх тал; Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 2021 он, 27 дахь тал.

2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр, Нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт цагдаагийн алба хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй “Ц” гэх иргэнд албадлагын арга хэмжээ авахдаа хүч хэрэглэн газарт унагаад гарыг нь ард нь гавлан хүзүүн дээр нь өвдөглөж буй бичлэг⁵⁵ олон нийтийн цахим сүлжээнд цацагдсан. Цагдаагийн Ерөнхий Газрын Хэвлэл мэдээллийн төвийн дарга Б.Баатархүү цагдаагийн алба хаагчийн шаардлагыг эсэргүүцсэн “Ц” гэгч нь урьд нь танхайрах зэрэг 37 удаа зөрчил гаргаж арга хэмжээ авагдаж байсан тухай мэдээлсний⁵⁶ улмаас цахим орчинд “Ц”-ийн нэр төрийг нь гутаах, доромжлох үйлдлүүд олонтаа гарсан.

Цар тахлын үеийн хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм зөрчсөн үйлдэлд холбогдуулан шалгаж байгаа иргэний хувийн мэдээллийг ийнхүү олон нийтэд мэдээлсэн нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.7.1-д заасан “шүүгч, прокурор, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах болон эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад олж мэдсэн хувь хүн, байгууллага, төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх, түүнийг хамгаалах арга хэмжээ авна”, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 12 дугаар зүйлд заасан “... хүний нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй, тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдахгүй байх, хувь хүний нууцыг задруулахгүй байх заалтыг зөрчжээ.

Түүнчлэн Ковидын халдвар авсан нь тогтоогдсон бөгөөд эрх бүхий байгууллагын тусгаарлах үйл ажиллагаанд саад учруулсан гэх Сэлэнгэ аймгийн оршин суугч иргэн “Б”-г цагдаагийн байгууллагаас эрэн сурвалжлах ажиллагаа явуулж саатуулах явцад хамгаалах хувцас өмсгөж байгаа зургийг⁵⁷ нийтэд мэдээлсэн нь цөөн хүн амтай орон нутагт тухайн иргэнийг хэн болохыг таамаглах, мэдэх боломж олгож улмаар нийгмийн зүгээс алагчлах, ялгаварлах, нэр төрийг нь гутаан доромжлох нөхцөлийг бүрдүүлжээ. Дээрх мэдээлэл нийтлэгдсэн цахим сүлжээнд иргэд тухайн иргэний хувийн мэдээлэл, эцэг, эхийн нэр, эрхэлдэг ажлын талаар тодорхой бичиж байсны зэрэгцээ “араас нь бензин цацаад шатаа”,⁵⁸ “овог нэрийг нь нийтэд дэлгэж, нийтээрээ жигшмээр байна”, “зугтаавал бууд”⁵⁹ гэх зэрэг сэтгэгдэл бичжээ. Энэ нь иргэдийг гутаан доромжлох, алагчлах нөхцөлийг бүрдүүлээд зогсохгүй хүчирхийлэл, дарамтад өртөх эрсдэлийг бий болгосон байна.

Цар тахлын халдвар авсан хүнийг тусгаарлах арга, журам тодорхойгүй, холбогдох байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоогүй, тусгаарлах арга хэмжээг олон нийтийн газарт хэрэгжүүлэх явцад тухайн хүнийг ялгаварлан гадуурхах, нэр төрийг нь гутаах, доромжлох болон аливаа халдлагаас хамгаалах орчин нөхцөлийг бүрдүүлээгүй нь хүний эрх зөрчигдөхөд хүргэж байна.

2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр “Нисэх-Гуравдугаар эмнэлэг” чиглэлийн автобусаар зорчиж явсан 17 настай иргэн “Ш”-ийн гар утас руу цагдаагийн байгууллагаас залгаж, ПГУ шинжилгээний хариу эерэг гарсан талаар мэдэгджээ. Мөн цагдаагийн байгууллагаас тухайн автобусыг зогсоох, ингэхдээ зорчигчдыг буулгахгүй байх үүргийг автобусны жолоочид өгчээ.⁶⁰ Улмаар автобусанд зорчиж явсан 30 гаруй хүнийг битүү орчинд 6 орчим цаг саатуулжээ. Энэ хугацаанд “Ш” 2 цаг автобусанд, харин үлдсэн дөрвөн цагийг өвлийн хүйтэнд (-15 градус) гадаа цагдаагийн хамгаалалтад зогсоогоороо өнгөрүүлжээ. Автобусанд зорчиж явсан зарим иргэд олон цаг автобусанд саатуулагдлаа хэмээн уурлаж бухимдан Ш-г хэл амаар доромжлох, зарим нь түүнийг цохихоор завдаж байсныг тус автобусанд зорчиж явсан иргэд хэвлэл мэдээллийн байгууллагад өгсөн ярилцлагадаа онцолжээ.⁶¹

“Ш” нь 18 насанд хүрээгүй байсан тул түүний эрх Хүүхдийн эрхийн тухай конвенци, Хүүхэд хамгааллын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор тусгайлан хамгаалагдах учиртай. Харин цар тахлын үед Хүүхдийн эрхийн тухай конвенцид заасан хүүхдийн дээд ашиг сонирхлыг хэрхэн хамгаалах, хүүхдийг алагчлах, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхгүй байх тусгай зохицуулалт, механизм Монгол Улсад дутмаг байгаа нь хүүхэдтэй хүнлэг бус, зүй бусаар хандах нөхцөлийг бүрдүүлж байна. Ковидын халдвартай нь тогтоогдсон хүүхдийг орон зайн хэт хязгаарлагдмал битүү орчинд бусад зорчигчдын хамт олон

⁵⁵ https://livetv.mn/p/2684802fbclid=IwAR3tDZiIQVAyd83gWpYvD8WZpgxIX5dMwMZAzVqvXyS_yFNuIFqkObLOE

⁵⁶ <https://eguur.mn/154774/> <http://time.mn/pgG.html>

⁵⁷ <https://ubn.mn/p/8489>

⁵⁸ Мөн тэнд

⁵⁹ <https://news.mn/r/2379800/>

⁶⁰ Хүний Эрхийн Үндэсний Комиссын 20 дахь тайлан илтгэл, 19

⁶¹ <https://isee.mn/n/18566>

цагаар байлгасан нь хүүхдийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд өвлийн хүйтэнд 4 цаг гаруй гадаа зогсоосон нь хүнлэг бус, хэрцгий хандсан үйлдэл юм.

2021 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Хөвсгөл аймагт коронавирусийн халдварын батлагдсан тохиолдлын ойрын хавьтал болсон иргэн 38 настай эмэгтэйг сумын төвийн эмнэлэгт хүргэхдээ түүнийг хол замд олон цагаар алхуулж араас нь цагдаагийн алба хаагч машинтай дагасан талаарх мэдээлэл олон нийтэд цацагдсан. Ийнхүү иргэнийг хол замд алхуулсан нь ялгаварлан гадуурхсан, хүнлэг бус хэрцгий хандсан үйлдэл болохыг ХЭҮК-ын тайланд онцолжээ.⁶² Харин Завхан аймагт коронавирусийн ойрын хавьтал болсон эмэгтэйг шинжилгээ хийлгэхийн тулд сумын төвийн гудамжаар 3 км орчим алхуулж араас нь цагдаа нар дагасан тохиолдол дахин гарсан талаар МОНЦАМЭ агентлагийн Завхан аймаг дахь сэтгүүлч мэдээлсэн.⁶³

5.6 ХҮНЛЭГ БУС ХАРЬЦАА



Хууль хэрэгжүүлэх нэг ч албан тушаалтан эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр харгис хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах аливаа үйлдлийг хийх, өдөөн хатгах болон эвлэрэнгүй хандаж болохгүй бөгөөд ингэж шийтгэхийг дээд албан тушаалтны өгсөн захирамж, дайны байдал, дайны аюул, үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн, улс төрийн тогтворгүй байдал болон бусад ямар ч онцгой нөхцөл байдлаар зөвтгөж болохгүй. Тэр дундаа эмзэг хэсгийнхэн болох хүүхэд, өндөр настан, эмэгтэйчүүд, дүрвэгчид, орон гэргүйчүүд, үндэсний цөөнх зэрэгт тусгай анхааралтай байх ёстой.

НҮБ-ын Хууль хэрэгжүүлэх албан тушаалтны зан үйлийн тухай хууль 1, 2, 5-р зүйл/ Бээжингийн Тунхаглал /2.2.4 параграф/

Хүний эрхийн олон улсын хэм хэмжээгээр эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлыг онц байдлын нөхцөл байдлыг хамааруулан ямар ч цаг үед хатуу хориглосон.⁶⁴

Харин иргэдийг албадан саатуулах, баривчлах, эрүүлжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ цагдаагийн байгууллага зүй бус харьцсан тохиолдол гарлаа. Цар тахлын үед албадан эрүүлжүүлж байгаа иргэдийг сул өрөө байсаар байтал нэг өрөөнд олноор нь байрлуулсан, гар ариутгагч, нэг удаагийн хамгааллын хэрэгслээр хангах ажиллагаа хангалтгүй хийгдэж байгаа нь ХЭҮК-ын эрүүлжүүлэх байранд хийсэн шалгалтаар тогтоогджээ.⁶⁵

2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 22:00-23:00 цагийн үед иргэн “Т”-г Дэнжийн 1000 дахь эрүүлжүүлэх төвд авчирч, албадан эрүүлжүүлэх арга хэмжээ авчээ. Түүнийг эрүүлжүүлэх байранд 12-13 орчим хүнтэй халдвар, хамгааллын дэглэм сахих, хүн хоорондын зай барих боломжгүй камерт оруулж, амны хаалт, гар ариутгагч нэхэж шаардлага тавьж маргахад нь цагдаа нар түүнийг зодсон⁶⁶ хэмээн хэвлэлд өгсөн ярилцлагадаа хэлжээ.

Өвлийн хүйтэн буюу 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн өглөөний 04:00 цагийн үед цагдаа нар иргэн О-г албадан эрүүлжүүлэхээр гэрээс нь нимгэн футболк, дотуур өмдтэй нь гадагш авч явж байгаа бичлэг нийгмийн цахим сүлжээнд цацагдсан.⁶⁷ Иргэн О хэвлэлд өгсөн ярилцлагадаа “цагдаа нар халдвар хамгааллын дэглэм баримтлаагүй, надад амны хаалт ч зүүлгээгүй. Эрүүлжүүлэх байранд драгерын хошууг солихгүйгээр хүмүүсээр үлээлгэж байсан”⁶⁸ хэмээн мэдээлсэн.

Ийнхүү албадан эрүүлжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ цагдаа нар иргэний биед хууль зөрчин халдсан, халдвар хамгааллын дэглэм сахиулаагүй үйлдэл нь Ковидын хууль, Албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 7.3.3 дахь заалт, Цагдаагийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлагыг илэрхий зөрчсөн, хүний халдашгүй байх эрхэд халдсан хүнлэг бус үйлдэл юм.

⁶² Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 2021 он, 28 дахь тал.

⁶³ Монголын Эмнести Интернэшнл, Нээлттэй нийгэм форумас хамтран 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан “Ковид-19 цар тахлын үеийн хууль сахиулах ажиллагаа: Чөлөөтэй зорчих эрх” хэлэлцүүлэг

⁶⁴ Article 5 of the Universal Declaration of Human Rights; UN Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment; Article 7 of the International Covenant on Civil and Political Rights; Article 5 of the African Charter on Human and Peoples' Rights; Article 5 of the American Convention on Human Rights; Article 8 of the Arab Charter on Human Rights; Article 3 of The European Convention on Human Rights and Fundamental Freedoms.

⁶⁵ Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 2021 он, 30 дахь тал.

⁶⁶ <https://said.mn/content/10/115488>

⁶⁷ <http://www.newstv.mn/a/677>

⁶⁸ <https://news.zindaa.mn/3iht>

Цагдаагийн алба хаагч болон албадан эрүүлжүүлэгдэж байгаа иргэдийг цар тахлын халдвар авах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор албадан эрүүлжүүлэх арга хэмжээ авахаас аль болох зайлсхийх, зайлшгүй тохиолдолд дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ халдвар, хамгааллын нэг удаагийн хувцас хэрэгслийг зохих шаардлагын дагуу хэрэглэх, тусгаарлах өрөөнд иргэдийг нэг дор олноор нь байрлуулахгүй байх, халууныг нь тогтмол шалгах, гар ариутгагч, амны хаалтаар хангах зэргээр халдвар хамгааллын аюулгүй байдлыг хангах нь нийгмийн болон иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад чухал ач холбогдолтой.

6. ДОТООДЫН ЗОРЧИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЯЗГААРЛАЛТ

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоолоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэн нь дотоодын зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох эхлэл болсон.

Цар тахлын эсрэг хуулийн 7 дугаар зүйлд улсын хилээр нэвтрэх болон дотоодын зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тодорхой хугацаанд хязгаарлалт хийх арга хэмжээ хэрэгжүүлэх эрхийг Засгийн газарт олгожээ. Засгийн газрын хэд хэдэн тогтоолоор⁶⁹ иргэд, тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлах хүрээг тогтоохыг бүх шатны онцгой комисст үүрэг болгосны дагуу тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зохих хязгаарлалт тогтоожээ.

**Нэг эрхийг
эдлүүлэхийн тулд
нөгөө эрхийг үгүйсгэж
болохгүй.**

Улсын Онцгой Комиссын шийдвэрээр 2020 оны 2 дугаар сарын 23-27-ны өдрүүд буюу цагаан сарын өдрүүдээр хот хоорондын зорчих хөдөлгөөнийг түр хязгаарлаж автобус, галт тэрэг, автомашинаар зорчих хөдөлгөөнийг түр хязгаарласан. Үүнээс хойш 2021 оны 6 дугаар сарыг дуустал хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэн шийдвэрийг 17 удаа сунгасан бол бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 5 удаа шилжүүлж, 2 удаа сунгажээ.



© www.mpa.mn. 2021 оны 4 дүгээр сарын 27. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үе.

Ялангуяа бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд хот хоорондын зорчих хөдөлгөөнөөс гадна хот доторх зорчих хөдөлгөөн, түүний дотор тээврийн хэрэгсэлтэй зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тогтоожээ. Түүнчлэн өндөржүүлсэн бэлэн байдал болон бүх

⁶⁹ Тухайлбал, Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 29-ний 194 дугаар тогтоол, мөн оны 12 дугаар сарын 9-ний Засгийн газрын 209 дугаар тогтоол, 12 дугаар сарын 21-ний Засгийн газрын 226 дугаар тогтоол, 2021 оны 2 дугаар сарын 10-ны Засгийн газрын 27 дугаар тогтоол, 4 дүгээр сарын 25-ны Улсын онцгой комиссын 04 дүгээр тогтоол

нийтийн бэлэн байдал зарласан хугацаанд коронавирусын халдвар авсан нь батлагдсан иргэдийн амьдарч байгаа нийтийн зориулалттай орон сууцнаас иргэдийн гарах хөдөлгөөнийг хязгаарласан.

Холбогдох эрх бүхий байгууллагын гаргасан зарим шийдвэр нь ойлгомжгүй, тодорхой бус, олон нийтэд боломжит хугацааны өмнө урьдчилан мэдэгдээгүй, хязгаарлалт үйлчлэхгүй байх тохиолдлыг тодорхой журамлан зохицуулаагүй, иргэний үндэслэл бүхий гаргасан хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх журам тодорхойгүй, олон нийтэд мэдээлэгдээгүй, хязгаарлалт үргэлжлэх хугацаа тодорхой бус байсан зэргээс үүдэн хүний амьд явах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ шуурхай авах, хөдөлмөрлөх зэрэг эрх зөрчигдсөн тохиолдол цөөнгүй гарчээ. Түүнчлэн зорчих хөдөлгөөний хязгаарлалттай холбоотойгоор гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрхийг хангах үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх журмыг тусгайлан журамлан зохицуулаагүйгээс хохирогчийн эрхийг хамгаалахад ихээхэн хүндрэл үүсчээ.⁷⁰

Засгийн газраас гэнэт гаргасан шийдвэрээр улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж орон нутгийн зорчих хөдөлгөөнийг хязгаарласны улмаас орон нутаг, нийслэлд хэдэн мянган⁷¹ иргэд олон хоногоор гацаж хувь хүн, өрх, аж ахуйн үйл ажиллагаанд олон төрлийн тулгамдсан асуудал үүссэн хэдий ч хүний эрх зөрчигдөх эрсдэлийг бууруулах чиглэлээр төрийн холбогдох байгууллагаас шуурхай үйл ажиллагаа явуулсангүй.^{72,73}

Эрдэнэт хотод оршин суугч “Б” ходоодны хорт хавдартай бөгөөд ээлжит үзлэгт хамрагдахаар Улаанбаатар хотод эхнэрийн хамт ирсэн боловч хөл хорио тогтоосноос хойш эмнэлгийн үйлчилгээ авч чадалгүй, хотын төв рүү орох, бусад үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэх боломжгүйгээр өвлийн хүйтэнд машиндаа 9 хоножээ.⁷⁴

Орон нутгийн зорчих хөдөлгөөнийг хязгаарласан шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодод цагдаа, эрүүл мэнд, мэргэжлийн хяналт, мал эмнэлэг, онцгой байдлын албан хаагчид ажиллажээ. Гэвч тэдгээр байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо, чиг үүргийн хуваарилалт, шийдвэр гаргалт, удирдах дээд байгууллагуудын мэдээлэл шуурхай солилцоо хангалтгүй, түүнчлэн хязгаарлалт үйлчлэхгүй байх үндэслэл, журам нь үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч болон иргэдийн хувьд ойлгомжгүй байсан нь хүний амь нас эндэх хүртэл ноцтой үр дагаврыг бий болгожээ.

2020 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 настай иргэн “О” Архангай аймгаас Улаанбаатар хотод ирэх замдаа бие нь муудаж 22-ийн товчоон дээр 22:00 цагийн үед ирээд ПГУ шинжилгээ өгөөгүй гэсэн үндэслэлээр хот руу нэвтэрч чадаагүйн улмаас эмнэлгийн тусламж авч чадалгүй 8-ны өдрийн 09:00 цагт нас баржээ. Тэрээр Архангай аймгаас гарахдаа түргэвчилсэн оношилгоо хийлгэсэн тухайгаа аймгийн Онцгой комисст хэлээд Улаанбаатар руу нэвтрүүлэх эсэхийг лавлаад, болно гэсэн хариуг үндэслээд замдаа гарчээ.⁷⁵ Улсын Онцгой Комисс цаг үеийн нөхцөл байдлыг зөв үнэлж чадаагүй, ажлын хариуцлага алдсан, асуудалд хүнлэг ёсоор хандаж түргэн шуурхай шийдвэрлээгүй, зохих арга хэмжээ аваагүй хүмүүст хариуцлага тооцохыг холбогдох шатны байгууллагад үүрэг болгожээ.⁷⁶ Уг хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.⁷⁷

Хот доторх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласан шийдвэрийг хэрэгжүүлэх явцад шийдвэрийн агуулгыг янз бүрээр ойлгож, тайлбарласнаас үүдэн иргэд болон цагдаагийн хооронд үл ойлголцол олонтоо гарчээ. Үүний улмаас зарим иргэдийн эмнэлгийн тусламж авах эрх, чухал шаардлагатай эм тариагаа авах боломж нь хязгаарлагджээ.

Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга Ж.Амгалан 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед яаралтай эмнэлгийн тусламж авах

⁷⁰ Монголын Эмнести Интернэшнл, Нээлттэй нийгэм форумгаас хамтран 2021 оны 7 дугаар сарын 8-ны өдөр зохион байгуулсан “Ковид-19 цар тахлын үеийн хууль сахиулах ажиллагаа: Чөлөөтэй зорчих эрх” хэлэлцүүлэг

⁷¹ “Зорчигч тээврийг зохицуулах түр журам”-ын дагуу 2020 оны 11 дүгээр сарын 26-ны байдлаар Улаанбаатар хотоос орон нутаг руу 86 мянга орчим хүн явахаар, харин орон нутгаас Улаанбаатар хот руу 5,300 гаруй иргэн ирэх хүсэлтээ www.119.mn вебсайтаар бүртгүүлсэн. <https://nema.gov.mn/n/109524>

⁷² Нээлттэй нийгэм форум, “Хөл хорио ба зорчих эрхийг хязгаарлах асуудал” ажиглалтын тайлан, 2020 оны 12 дугаар сар. http://forum.mn/res_mat/2020/OSF_COVID-19_7.pdf

⁷³ Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 2021 он, 141-146 дахь тал. <http://isee.mn/n/15800>

⁷⁴ Хулангах, Хэргийн газар: Талийгаач эмэгтэй “Нойр булчирхай өвдөөд байна” хэмээн байнга хэлж байжээ, 2020-12-09, <http://www.isee.mn/index.php/n/16392>

⁷⁵ <https://www.montsame.mn/en/read/246052>

⁷⁶ <https://gogo.mn/r/60qvd>

шаардлагатайгаас бусад тохиолдолд хувийн автомашин хөдөлгөөнд оролцуулахыг хориглож, эмнэлэг рүү явах бол эмнэлгийн байгууллагаас эхлээд хамгаалалтад гарч байгаа төрийн албан хаагчид эхэлж хандаад түргэн хүргэх ажлыг зохион байгуулна хэмээн мэдэгджээ.⁷⁸

Гэвч бодит байдалд эмнэлгийн яаралтай тусламжийн хүрэлцээ муу, нийтийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнд цагийн хязгаарлалт тогтоосон, замын цагдаад нөхцөл байдлаа тайлбарлаж, эмнэлэгт үзүүлэх баримт материалаа үзүүлээд ч хувийн тээврийн хэрэгслээр эмнэлэг явах боломж олгоогүй тул хүүхдээ тэврээд өвлийн хүйтэнд эмнэлэг рүү алхсан нь⁷⁹ эмнэлгийн тусламж үйлчилгээ түргэн шуурхай авах эрхийг зөрчсөн, иргэдэд хүнлэг бус хандсан үйлдэл байлаа.

“Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн 13 салбарын ажиллагсад ажилдаа очихын тулд заавал ПГУ шинжилгээ өгсөн байх ёстой. Ийм бичиггүй бол замын хөдөлгөөнд оролцуулахгүй” гэсэн шаардлагыг өчигдөр өглөөнөөс замын цагдаагийн алба хаагчид иргэдэд тавьж эхлэв. Хамгийн гол нь урьдчилан мэдэгдээгүй хэрнээ гэнэт ийм шаардлага тавьсанд иргэд ихэд бухимдсан юм. Бас шинжилгээний хариу 72 цагийн хүчинтэй гэсэн шийдвэрийг хэн нэгэн албан тушаалтан гаргажээ. Гэтэл УОК-ын хэвлэлийн төлөөлөгч Ц.Ганзориг хэдхэн хоногийн өмнө буюу 2 дугаар сарын 13-ны өдөр зөвшөөрөгдсөн 14 салбарын ажилтнуудаас ПГУ шинжилгээний хариу шаардсан зүйл байхгүй. Энэ мэт ойлголтын зөрүүтэй асуудлыг засаж залруулна гэжээ. Харин Засаг дарга Д.Сумъяабазар шинжилгээний бичиг 72 цаг гэдэг нь ташаа мэдээ гэжээ.”⁸⁰

Ийнхүү тээврийн хэрэгслээр зорчих хөдөлгөөний хязгаарлалттай холбоотой холбогдох байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх явцад үл ойлголцол үүссэнээс 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн Нийслэлийн шуурхай штабын 1800-1200 дугаарт ирсэн дуудлагын 25 хувийг цагдаагийн алба хаагчидтай холбоотой гомдол эзэлжээ.⁸¹

Коронавирусийн халдвар илэрсэн иргэний амьдардаг нийтийн зориулалттай орон сууцыг цагдаагийн хамгаалалтад авч, иргэдийн орох, гарах хөдөлгөөнийг тодорхойгүй хугацаагаар хязгаарласны улмаас иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, хоол хүнсээр хангагдах, чухал шаардлагатай эм, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, эрүүл аюулгүй орчинд амьдрах зэрэг эрх нь зөрчигдсөн байна.

2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр Баянзүрх дүүрэгт байрлах Х Apartment орон сууцны СӨХ-ийн ажилтан коронавирусийн халдвар авсан нь тогтоогдсон тул уг орон сууцны Б блокын бүх оршин суугчдыг шинжилгээнд хамруулахад нийт 8 иргэнээс халдварын тохиолдол илэрчээ. Иймээс Баянзүрх дүүргийн Онцгой комиссоос халдвар тархах эрсдэл өндөр хэмээн үзэж тухайн орон сууцыг ажиглалт, хамгаалалтад⁸² авснаар 400 айлын 1200 орчим иргэний гарах хөдөлгөөнийг хязгаарлажээ. 9 хоногийн турш ажиглалт хамгаалалтыг хэрэгжүүлсэн хэдий ч цаашид хэдий хугацаагаар үргэлжлэх нь тодорхойгүй, түүнчлэн орон сууцны айл, өрхийн хог, хаягдлыг зайлуулаагүйгээс бөөгнөрсөн хог оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа зэргээс үүдэн оршин суугч иргэдийн төлөөлөл эсэргүүцлээ илэрхийлэн 2 дугаар сарын 5-ны өдөр цуглажээ.⁸³ 2021 оны 2 дугаар сарын 6-ны өдөр хамгаалалтыг цуцалсан байна

Орон сууцыг ажиглалт, хамгаалалтад авахдаа тухайн оршин суугчдад урьдчилан мэдэгдэх, ялангуяа оршин суугч бус иргэний асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид баримтлах нэгдсэн аргачлал, процесс тодорхойгүй байсны улмаас зарим иргэн өвлийн хүйтэнд орцонд хоносон тохиолдол гарчээ.

Баянзүрх дүүргийн “Аман хуур” хотхоны дөрвөн давхрын оршин суугчаас коронавирус илэрсэн тул 2020 оны 11 дүгээр сарын 27-нд уг орон сууцанд ажиглалт, хяналт тавих зорилгоор цагдаагийн хамгаалалт тогтоожээ. Үүний улмаас тухайн өдөр “Аман хуур” хотхоны нэгдүгээр давхрын айлд засвар хийхээр өдрийн 11 цагт очсон засварчин “Э” гарах боломжгүй болж, тэр шөнөдөө орцонд, плитан шалан дээр хоножээ. Тэрээр холбогдох утасны дугаар руу залгасан ч хариу өгөөгүй аж. Дараа өдөр нь түүнийг зочид буудалд тусгаарласан байна.⁸⁴

⁷⁸ Ж.Амгалан, Хөл хорионы үеэр хувийн машин явах тохиолдол нь эмнэлгийн яаралтай тусламж болон гачигдал, (2021.02.10), <https://ikon.mn/n/24li>

⁷⁹ МҮОНРТ-ийн сурвалжлах багийн 2021 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн мэдээ

⁸⁰ Урваж хөрвөсөн шийдвэрүүдийн учир нь олдохоо болив, Өнөөдөр сонин, 2021-2-16, <https://unuudur.mn/145708/>

⁸¹ Нийслэлийн Замын хөдөлгөөн төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газрын дарга, хурандаа С.Энхтөр <https://news.mn/r/2401257/>

⁸² Д.Тэмүүлэн, “Х apartment хотхоны бөөгнөрсөн хогийг энэ сарын 1, 2-ны өдрүүдэд ачсан” 2021.02.06 <https://ikon.mn/n/24ez>

⁸³ https://www.facebook.com/watch/live/?ref=watch_permalink&v=440363274046341

⁸⁴ Б.Буяндалай, Э.Эрдэнэбаяр: Засвар хийхээр очсон өдрөө “Аман Хуур” хотхонд тусгаарлагдан, орцонд шалан дээр хоносон, 2020-12-02. <https://eguur.mn/158709/>

7. ОРОН ГЭРГҮЙ ИРГЭДИЙГ ТУСГААРЛАСАН БАЙДАЛ



Арьс өнгө, хүйс, бэлгийн чиг хандлага, нас, хэл соёл, шашин шүтлэг, үндэс угсаа, улс төрийн үзэл бодол, тахир дутуу, нийгмийн болон язгуурын гарал зэргээсээ ялгаварлагдаж болзошгүй хохирогчдод тусгай анхаарал тавих.

НҮБ-ын Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал /зарчим 4, 14, 15, 16, 17/, ЭЯГБХУТ Конвенцийн /11-р хэсэг/

Орон гэргүй эсхүл шаардлагад нийцэхгүй орон байранд амьдарч байгаа хүмүүсийг хамгаалахын тулд улс орнууд наад зах нь дараах арга хэмжээнүүдийг авах ёстой. Үүнд: нүүлгэн шилжүүлэлтийг зогсоох; халдвар авсан, авах эрсдэлтэй, тусгаарлагдах шаардлагатай хүмүүсийг яаралтай орон байр, үйлчилгээгээр хангах; хөл хорио зэрэг хязгаарлалтын зарим арга хэмжээ нь орон байргүй хэн нэгнийг хорио цээрийн дэглэм зөрчсөн гэсэн шийтгэл болох ёсгүйг баталгаажуулах; эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, шинжилгээ оношлогоонд тэгш хамруулах; улсын онцгой байдлын үед шаардлагатай тусгай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхдээ энэ хүмүүсийг сул болон орхигдсон барилга, байгууламж мөн богино хугацаанд түрээслэх боломжтой шаардлагад нийцсэн орон байраар хангах ёстой.

Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай Илтгэгчийн мэдэгдлээс. 2020 оны 3 дугаар сарын 18. Женев.

Орон гэргүй хүмүүс нь цар тахалд өртөх өндөр эрсдэлтэй нийгмийн бүлэгт хамаардаг. Учир нь тэд эрүүл мэндийн байгууллагаас өгч байгаа анхааруулга, санамж, зөвлөгөө мэдээллийг хүртээмжтэй байдлаар шуурхай авч чаддаггүй, эрх бүхий байгууллагаас тогтоосон хөл хорио, хязгаарлалтын дэглэмийг сахих боломж хязгаарлагдмал байдаг. Иймд төрөөс орон гэргүй хүмүүс рүү чиглэсэн хамгааллын тусгай бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Ковидын хуулийн 7 дугаар зүйлд цар тахлын үед орон гэргүй, нэн ядуу иргэдийг орон байр, сайжруулсан түлш, хоол хүнс, ундны цэвэр усаар хангах, халдвараас сэргийлэх ажлыг Засгийн газраас хэрэгжүүлэхээр заасан.

Орон нутгийн удирдлагаас гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг олж илрүүлэх, гэр бүлд нь нэгтгэх, түр хамгаалах байранд хүргэх, ковидын шинжилгээнд хамруулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Тухайлбал, Нийслэлийн засаг даргын 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн “Гэр оронгүй иргэдийн талаар авах арга хэмжээний тухай” А/345 дугаар захирамжийн дагуу 2020 оны 3 дугаар сарын 17-ны байдлаар нийт гэр оронгүй, тэнэмэл амьдралтай 382 иргэнийг нийслэлийн засаг даргын дэргэдэх нийгмийн хамгааллын тусгай төвд байршуулж дээрх иргэдээс 154 иргэнийг ар гэрт нь хүлээлгэн өгч, 145 иргэнийг тус төвд байршуулж эрүүл мэнд болон бусад төрлийн үйлчилгээ үзүүлжээ.⁸⁵ 2020 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар гэр оронгүй, тэнэмэл 420 гаруй иргэнийг түр хоноглох газарт байршуулжээ.

Нийслэлийн цагдаагийн газрын зарим удирдлагатай хийсэн уулзалтын үеэр цагдаагийн алба хаагчид гэр оронгүй, тэнэмэл иргэдийг цуглуулах олж илрүүлэх үйл ажиллагаанд баримтлах албан ёсны журам байхгүй хэдий ч, цагдаагийн хувьд НОК-оос гаргасан журмыг баримтлан хүн хоорондын зайг барих, халдвар хамгааллын дэглэм баримтлан ажилласан гэжээ.⁸⁶

Иргэн Ө: 2020 оны 11 дүгээр сард цагдаа нар халуун уух зүйл өгье дагаад яваарай гэж хэлээд машинд суулган авч яваад ковидын шинжилгээнд хамруулсан. Дараа нь биднийг нэгдсэн журмаар түр байранд хүргэсэн.⁸⁷

⁸⁵ Нийгмийн хамгааллын тусгай төвд орон гэргүй 145 иргэнийг түр байрлуулжээ, 2020.03.17, <http://eagle.mn/r/70089>

⁸⁶ Судалгааны багийн Нийслэлийн цагдаагийн байгууллагын албаны хүмүүстэй хийсэн уулзалтын тэмдэглэлээс

⁸⁷ Судалгааны багийн орон гэргүй иргэдтэй хийсэн уулзалтын тэмдэглэлээс

Иргэн Х: цагдаа нар биднийг түүхий эд аваачиж тушаадаг байсан газар хүлээж байгаад үүрч явсан түүхий эдийг тушаалгасны дараагаар албадлага хэрэглэн пургон машинд 8-10 хүн суулгаж шинжилгээнд хамруулан дараа нь түр амьдрах байр руу хүргэж өгсөн.⁸⁸

Иргэн Ц: Шинжилгээ хийлгэхээр болон тухайн түр байрлуулах байранд хүргэгдэх явцад та очихгүй байх эрхтэй гэдэг зүйл огт хэлээгүй. Зүгээр л суу гэж албадаад аваад явсан.⁸⁹

Дээрх үйл ажиллагааг Нийслэлийн засаг даргын тамгын газрын нийгмийн бодлогын хэлтэс, Нийслэлийн нийгмийн халамжийн газар, нийслэл, дүүргийн цагдаагийн хэлтэс хамтран зохион байгуулжээ. Дүүргийн цагдаагийн хэлтсүүд өөрийн хариуцан ажиллаж буй нутаг дэвсгэр дэх гэр оронгүй, тэнэмэл байдлаар амьдардаг иргэдийг олж тогтоох, цуглуулах, бүртгэлжүүлэх ажлыг гүйцэтгэснээс гадна түр хоноглох байранд байршуулах, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах төрийн болон төрийн бус байгууллагуудад шилжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлжээ.⁹⁰ Дээрх арга хэмжээг цагдаагийн байгууллагаас хэрхэн зохион байгуулах, ялангуяа арга хэмжээнд сайн дураар хамрагдахаас татгалзсан иргэдтэй хэрхэн харилцах арга, журам тодорхойгүй байсан нь тэдгээр иргэдэд хууль бусаар хүч, албадлага хэрэглэх эрсдэлийг бүрдүүлжээ.

⁸⁸ Судалгааны багийн орон гэргүй иргэдтэй хийсэн уулзалтын тэмдэглэлээс

⁸⁹ Судалгааны багийн орон гэргүй иргэдтэй хийсэн уулзалтын тэмдэглэлээс

⁹⁰ Нийслэлийн хэмжээнд нийт 420 гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг түр хоноглох, байршуулах үйлчилгээнд хамрууллаа, 2020.11.20, <https://mlsp.gov.mn/content/detail/914>.

8. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧ БА ДХИС-ИЙН СОНСОГЧДЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

8.1 СОНСОГЧДЫГ ДАЙЧИЛСАН БАЙДАЛ

2020 оны 2 дугаар сараас эхлэн Дотоод хэргийн их сургуулийн (ДХИС) сонсогчид цагдаа болон дотоодын цэргийн албан хаагчдад дэмжлэг үзүүлэн ажилласан.⁹¹ Харин Засгийн Газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед ДХИС-ийн захирлын “Хүч нэмэгдүүлэн хамгаалалтад шилжүүлэх тухай” А/246 дугаар тушаалаар тус сургуулийн багш, албан хаагч, сонсогчид нийт 2150 бүрэлдэхүүн⁹² цагдаагийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэж буй нийт 42 тусгаарлах байр, хяналтын 192 цэг, явган эргүүлийн 1,100 чиглэл, машинт эргүүлийн 107 чиглэлд⁹³ хамтран үүрэг гүйцэтгэжээ.

Цагдаагийн албаны тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4-т “Цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын алба хаагч болон 18 насанд хүрсэн суралцагчийг онцгой тохиолдолд нийтийн хэв журам хамгаалах ажилд оролцуулж болох бөгөөд энэ тохиолдолд цагдаагийн алба хаагчид хуулиар олгосон баталгаа тэдгээрт нэгэн адил үйлчилнэ” хэмээн заасан.

Харин ДХИС-д суралцаж байгаа хилчин болон онцгой байдлын алба хаагч-суралцагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч-суралцагчдыг онцгой тохиолдолд хүч нэмэгдүүлэн дайчлах талаарх харилцааг хуулиар зохицуулаагүй бөгөөд тэдгээрийг ямар баталгаагаар хангах эсэх нь тодорхойгүй байна. Үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын 49 хувь нь цагдаагийн алба хаагч-суралцагч, 27.1 хувь нь хилчин, 20.1 хувь нь онцгой байдлын алба хаагч-суралцагч, 3.8 хувь нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч-суралцагч байжээ.⁹⁴ ДХИС-ийн сонсогчдыг хууль сахиулах үйл ажиллагаанд хүч нэмэгдүүлэн ажиллуулсан нь гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмийг сахиулахад чухал дэмжлэг болсон гэж үзээд Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэрээр үүрэг гүйцэтгэсэн сонсогчдод 420.000 төгрөгийн нэг удаагийн урамшууллыг олгожээ.

Судалгааны явцад олж авсан мэдээлэл болон зарим сонсогчидтой хийсэн ярилцлагаас үзэхэд Дүүргийн цагдаагийн хэлтэс болон ДХИС-ын удирдлага, офицер багш нар сонсогчдыг үүрэг гүйцэтгэхэд нь шаардлагатай зарим удирдамж, зөвлөмж, арга зүйгээр ханган ажиллажээ.

ДХИС-ийн тэргүүн дэд захирлын 2021 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр баталсан “Дотоод хэргийн их сургуулийн алба хаагч, суралцагчдад гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед ажиллах зөвлөмж”⁹⁵-д сонсогчид үүрэг гүйцэтгэх явцад гэмт хэрэг, зөрчил илэрвэл холбогдох байгууллагад мэдээлэх, тодорхой цэгүүдэд дэг журам сахиулах болон иргэдтэй харилцахад баримтлах журам болон халдвар хамгааллын аюулгүй байдлыг хангах талаар тусгажээ.

*Сонсогч 01: үүрэг гүйцэтгэлтэй холбогдох шинэчлэгдсэн тушаал, журмуудыг цахим сүлжээ ашиглан ангийн дарга бусад албан хаагчдаас авч байсан.*⁹⁶

*Сонсогч 02: Удирдамжтай танилцсан. Бидний хуваарилагдсан хэлтсээс өдөр бүр холбогдох албан тушаалтнууд шалгалт хийж, иргэдтэй ёс зүйтэй харилцах, соёлтой байх, халдвар хамгааллын аюулгүй байдлыг сахих, хүн хоорондын зай барих, дур мэдэн шийдвэр гаргахгүй байх талаар зааварчилгаа өгдөг байсан.*⁹⁷

⁹¹ Тухайлбал, 2020 оны 2 дугаар сарын 21-нээс 3 дугаар сарын 2-ныг хүртэлх хугацаанд ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн 164 сонсогч Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх цагдаагийн байгууллагуудад үүрэг гүйцэтгэжээ. <https://uia.gov.mn/news-details/101>

⁹² <https://mojha.gov.mn/newmojha/?p=4490&fbclid=IwAR2BtTtCp6G5y4q8HwLWYmaxFNY0M1x-JFHWAfS3d1Xo7Y1Bz-XB9R11g>

⁹³ Их сургуулийн 2150 багш, албан хаагч, сонсогчид нийслэлийн зургаан дүүргийн Цагдаагийн газар, хэлтсүүдэд эргүүл, хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байна, 2020.11.12, <https://www.uia.gov.mn/entrant-detail/210>.

⁹⁴ Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 271

⁹⁵ ДХИС-ийн тэргүүн дэд захирлын 2021 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн тушаалаар батлагдсан Дотоод хэргийн их сургуулийн алба хаагч, суралцагчдад гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед ажиллах зөвлөмж”

⁹⁶ Судалгааны багийн ДХИС-ийн сонсогчидтой хийсэн уулзалтын тэмдэглэл

⁹⁷ Судалгааны багийн ДХИС-ийн сонсогчидтой хийсэн уулзалтын тэмдэглэл

Сонсогч 03: Журам удирдамжтай холбоотой ойлгомжгүй нөхцөл тохиолддог. Түүнчлэн иргэдэд шаардлага тавих, бичиг баримт шалгах тохиолдолд эсэргүүцдэг байсан. Энэ үед хамтран үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчаас чиглэл авч ажиллаж байсан.⁹⁸

2020 оны 11 дүгээр сард Засгийн газраас гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал зарласан хугацаанд сонсогчид 07:30-14:30, 14:30-21:30 цагийн хооронд хоёр ээлжээр үүрэг гүйцэтгэн ажиллажээ. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал зарласан хугацаанд тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд иргэд хувийн машинаар зорчихыг хориглосон, түүнчлэн нийтийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнд цагийн хязгаарлалт тогтоосон байсан нь сонсогчид үүрэг гүйцэтгэх цэг рүү очих болон буцахад хүндрэлтэй байжээ. Хожим нь үүрэг гүйцэтгэж буй сонсогчдыг тогтоосон үүрэг гүйцэтгэх цэгт тээврийн хэрэгслээр хүргэх, авах арга хэмжээг нэгдсэн журмаар зохион байгуулснаар дээрх хүндрэлийг зарим талаар шийдвэрлэжээ.

Сонсогч 04: Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал зарлаж эхэлсэн үед сургуулиас бидэнд үйлчилсэн автобусны маршрут зөвхөн төв замаар нэг цэгээс нөгөө цэг хүртэл явдаг байсан учраас тухайлбал Дарь эх рүү зорчих боломжгүйгээс зарим тохиолдолд орой алхаж гэртээ харьдаг байсан. Харин нийтийн тээврийн хэрэгсэл энгийн цагийн хуваариар тээвэрлэлт хийж эхлэх үед үүрэг гүйцэтгэх цэг рүү зорчиход ямар нэгэн хүндрэл үүсдэггүй байсан.

-40 градус хүртэл хүйтэрсэн өвлийн хүйтэнд үүрэг гүйцэтгэж байгаа сонсогчдын хувцас хэрэглэл нь шаардлагад нийцээгүй байсныг зарим хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон иргэд онцолж байлаа.^{99,100} Үүрэг гүйцэтгэж байсан нэгэн сонсогчийн гар хайрагдаж эмнэлгийн тусламж авсан тохиолдол гарчээ.¹⁰¹

ДХИС-д сурч байгаа орон нутгаас ирсэн эчнээ ангийн болон офицерын дамжаанд суралцаж байгаа 100 гаруй албан хаагчдыг өвлийн хүйтэнд үүрэг гүйцэтгүүлэхээр дайчлан ажиллуулсан. Тэдний хувьд орон гэртээ харих боломжгүй тул нийслэлд хамаатан садан, найз нөхдөө бараадан амьдарч байсан ч сүүлдээ амьдарч байгаа хүмүүс нь цэрвэх болсноор очих газаргүй, зарим нь сургуулийн манаачтай хамт хоноглосон ч тохиолдол гарсан. Танхимд хичээллэхээр ирсэн албан хаагчид дулаан хувцасгүй хэсэг зутарсан.¹⁰²

Цар тахлын үед сонсогчид үүрэг гүйцэтгэх явцдаа гэмт халдлагад өртсөн, коронавируст халдвар туссан, хүний эрхэд халдсан тохиолдол бүртгэгдээгүй хэмээн ХЭҮК-ын тайланд дурджээ.

8.2 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ХАМГААЛАЛ

Цар тахлын үед цагдаагийн алба хаагчид нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээс гадна Улсын болон орон нутгийн онцгой комиссын хуралдаанаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу цар тахлын ойрын болон дам хавьтлын хүмүүсийг тусгаарлах, тусгаарлах байруудын аюулгүй байдлыг хангах, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед тогтоосон дэглэмийг сахиулах, жагсаал, цуглаан, суултын үеэр дээд удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх зэрэг нэмэлт олон төрлийн үүрэг гүйцэтгэсэн. Энэ нь цагдаагийн албан хаагчдын ажлын ачааллыг эрс нэмэгдүүлж, хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлжээ.

Ялангуяа, хуульд зааснаас илүү цагаар ажилласан, нийтээр амрах болон тэмдэглэлт өдрүүдэд ажилласан алба хаагчдыг нөхөн амруулаагүй, хуульд заасан нэмэлт хөлсийг олгоогүй, ээлжийн амралтаа биеэр бүрэн эдлээгүй албан хаагчдад хуульд заасан мөнгөн урамшууллыг олгоогүй зэргээр хууль тогтоомжийг ноцтой зөрчжээ.¹⁰³

⁹⁸ Судалгааны багийн ДХИС-ийн сонсогчидтой хийсэн уулзалтын тэмдэглэл

⁹⁹ Сонсогчдод хангалтаар өгсөн илчгүй хувцас "ГОЛОГДЖЭЭ", 2020-01-05, <https://eguur.mn/168332/>.

¹⁰⁰ Б.Баатархүү: Иргэд явган болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөө багасгавал алба хаагчид олноороо хүйтэнд зогсох шаардлагагүй болно, (2021-01-06), <http://itoim.mn/article/mfm6R/25288>.

¹⁰¹ Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 271.

¹⁰² Судалгааны багийн "Цагдаагийн алба хаагчдын эрх ашгийг хамгаалах холбоо"-той хийсэн уулзалтын тэмдэглэл

¹⁰³ Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 255-259.

Мөн гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал зарласан хугацаанд цаг агаарын эрс, тэрс хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчдын ажиллах орчин, нөхцөлөөр хангах асуудал чухлаар хөндөгдлөө. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед нийтийн гудамж талбайд эргүүл хамгааллын үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид түр амрах, дулаацах байргүй, бие засах газаргүй орчинд цаг агаарын хүнд нөхцөлд олон цагаар үүрэг гүйцэтгэжээ. Түүнчлэн цагдаагийн байгууллагаас цагдаагийн алба хаагчдыг хувийн унаагаар зорчихыг хязгаарлаж, нийтийн тээврийн хэрэгслээр зорчих үүрэг чиглэл өгсний улмаас цагдаагийн албан хаагч нийтийн тээврийн хэрэгслээр зорчих боломжгүй үед үүрэг гүйцэтгэх газартаа бэлэн байхын тулд олон цагаар алхах зэрэг хүндрэл бэрхшээл гарсан талаар Цагдаагийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах холбоонд алба хаагчид ханджээ.¹⁰⁴

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед 24 цагийн турш гурван ээлжээр эргүүл хамгааллын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг нэгдсэн хоол хүнсээр хангаагүй, олгосон хүнсний хангалт нь хүртээмжтэй бус, хоол хүнсний хэмжээ бага, чанар муу байсан тухай цагдаагийн алба хаагчид онцолжээ. Эдгээр цагдаагийн алба хаагчийн хүний эрхийн асуудлыг ХЭҮК-ын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлд дэлгэрэнгүй дурдсан байна.

Цар тахалтай тэмцэх тэргүүн эгнээнд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчдыг халдвар хамгааллын хэрэгслээр хангах асуудалд цагдаагийн байгууллагаас анхааран ажиллаж байгаа хэдий ч хамгаалах хэрэгслийн нэр төрөл, нөөц, хүртээмж хангалттай бус байлаа.¹⁰⁵ Ялангуяа, жагсаал, цуглааны үед хүч албадлага хэрэглэх, согтууруулах ундаа хэтрүүлсэн этгээдийг эрүүлжүүлэх, хэрэг, зөрчилд холбогдсон иргэнийг албадан саатуулах зэрэг тохиолдолд Ковидын халдвар тархах өндөр эрсдэлтэй бөгөөд амны хаалт, гар ариутгагч зэрэг нь халдвар хамгааллын аюулгүй байдлыг бүрэн хангаж чадахгүй юм.

2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар цагдаа, дотоодын цэргийн нийт алба хаагчдаас 1588 алба хаагч ковидын халдвар авчээ.¹⁰⁶ Гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд үүрэг гүйцэтгэж байх хугацаанд халдвар авсан болон ачаалалтай ажилласан зарим алба хаагчдыг сувилалд амрах зэрэг зохион байгуулалтын үйл ажиллагааг цагдаагийн байгууллагаас зохион байгуулж байгаа талаар мэдэгдсэн.¹⁰⁷ Гэвч цар тахлын үед эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байхдаа коронавирусын халдвар авсан төрийн алба хаагчид нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох асуудлыг шийдвэрлэх талаарх Ковидын хуулийн зохицуулалтын хэрэгжилт тун хангалтгүй байна.¹⁰⁸ Цаашид үүрэг гүйцэтгэж байхдаа халдвар авсан цагдаагийн алба хаагчид хуульд заасан нэг удаагийн тэтгэмж олгох, даатгалд хамруулах, даатгалын нөхөх олговор олгох асуудалд анхааран ажиллах шаардлагатай байна.

Коронавирусийн эсрэг вакцинд эмнэлэг, цагдаа, онцгой байдлын алба хаагчдыг тэргүүн ээлжинд хамруулах бодлогыг төрөөс авч хэрэгжүүлсэн. Гэвч эрүүл мэндийн хувьд вакцины эсрэг заалттай цагдаагийн албан хаагчийг “дархлаажуулалтад хамрагдахгүй бол ажлаас хална” гэж сүрдүүлсний улмаас¹⁰⁹ Увс аймагт цагдаагийн 2 алба хаагч вакцины хоёрдахь тунг хийлгэсний дараа нас барсан гэсэн мэдээлэл олон нийтэд цацагдсан. Харин цагдаагийн байгууллага болон холбогдох төрийн захиргааны байгууллагаас тэдгээр алба хаагчийг албадан вакцинжуулалтад хамруулаагүй бөгөөд нас барсан шалтгаан нь вакцинтай хамааралгүй хэмээн мэдэгдсэн байна.¹¹⁰

Төрийн болон орон нутгийн холбогдох байгууллагаас цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж байгаа ойлгомжгүй, тодорхойгүй шийдвэрийг хэрэгжүүлэх, түүнчлэн тайван жагсаал, цуглааныг албадан тараах зэрэг үйл ажиллагааны явцад иргэд, олон нийт болон цагдаагийн алба хаагчдын хооронд үүссэн үл ойлголцол маргаан нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн нэр хүнд унах, олон жилийн туршид тогтсон итгэлцэл, харилцааг үнэгүйдүүлж байна.

Түүнчлэн цагдаагийн удирдах дээд байгууллагаас цагдаагийн нийт алба хаагчдад холбогдох шийдвэр, удирдамж, зөвлөмжийг мэдээлэх, түүнтэй нэг бүрчлэн танилцах боломж бүхий үр нөлөөтэй мэдээллийн сувгийг бий болгож, мэдээллийг шуурхай хүлээн авах, солилцох тогтолцоог сайжруулах шаардлагатай. Цагдаагийн албан хаагч зохих төрийн байгууллагаас

¹⁰⁴ Судалгааны багийн “Цагдаагийн алба хаагчдын эрх ашгийг хамгаалах холбоо”-ны тэргүүн Н.Алтанбаатартай хийсэн уулзалтын тэмдэглэл

¹⁰⁵ Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 266.

¹⁰⁶ Цагдаагийн Ерөнхий Газрын 2021.09.07-ны өдрийн 2/333 тоот албан бичгийн хавсралт.

¹⁰⁷ Мөн тэнд

¹⁰⁸ Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 267

¹⁰⁹ <https://unwudur.mn/159789/>

¹¹⁰ А.Амарбат, Ковидын вакцины улмаас цагдаагийн алба хаагч нас бараагүй, 2021-05-06. <https://police.gov.mn/a/5515>

гаргасан шийдвэрийг уншиж танилцаагүй, нэгдсэн журмаар нэг мөр ойлгоогүй нь шийдвэрийг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, эцэстээ иргэд, алба хаагчдын хооронд маргаан үүсэх эрсдэлийг нэмэгдүүлсэн.

Иймээс цар тахлын үеийн цагдаагийн үйл ажиллагааг хүний эрхийн хандлага, олон улсын сайн туршлагад нийцүүлэн төлөвлөн, зохион байгуулах шаардлагатай байна. Цагдаагийн байгууллагын дотоод үйл ажиллагааг төлөвлөхдөө ажиллах хүчний нөөцийн хомстолд орохоос сэргийлэх, одоогийн хүний нөөцийг урт хугацаанд үр нөлөөтэй удирдах, шаардлагатай халдвар хамгааллын хэрэгслээр тасралтгүй хангах нөөцийг бүрдүүлэх, цар тахлын халдвар авсан цагдаагийн алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, цагдаагийн албан хаагчдаас үүргээ гүйцэтгэх нөхцөлийг хангахын тулд тэдний гэр бүлд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх, гэр бүлийн гишүүдэд шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх зэрэг асуудлыг чухалчлан авч үзэх шаардлагатай.

Ковид-19 цар тахалтай тэмцэх талаарх үндэсний төлөвлөгөөнд цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааг чухлаар авч үзэн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газрын Цагдаагийн хэлтсээс боловсруулан гаргасан “Цар тахлын үед цагдаагийн үйл ажиллагааг төлөвлөх нь” гарын авлагыг¹¹¹ цаашид цар тахлын үед Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ашиглах боломжтой.

Цаг агаарын болон гамшиг хямрал, цар тахлын хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчдын хүсэлт, шаардлагыг анхаарч, тэдний гаргасан гомдлыг шийдвэрлэх, аливаа шаардлага, хүсэлт, саналаа холбогдох удирдлагадаа илэрхийлснийхээ төлөө эрх, ашиг сонирхол нь зөрчигдөхгүй байх баталгааг хангах асуудал чухлаар хөндөгдөж байна.

¹¹¹ Police Division of United Nations Department of Peace and Operations, United Nations Development Programme, Police Planning during a Covid-19 Pandemic, Guidance Note, 15 April 2020 <https://www.un.org/ruleoflaw/wp-content/uploads/2020/06/Guidance-Note-on-Police-planning-during-a-covid-19-pandemic-Final.pdf>

9. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ МЕХАНИЗМ

Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргах шийдвэр, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) хэрэгжүүлэхээр Ковидын хуульд заасан. ХЭҮК-оос хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар,¹¹² Улсын Онцгой Комисс,^{113,114} Эрүүл мэндийн сайд,¹¹⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага,¹¹⁶ Цагдаагийн Ерөнхий Газар¹¹⁷ зэрэг бусад байгууллага, албан тушаалтанд зөвлөмж, шаардлага хүргүүлэн ажилласан нь төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас хүний эрх зөрчигдөх шалтгаан нөхцөлийг бууруулах, арилгахад зохих нөлөө үзүүлсэн.

Гэвч ХЭҮК-ын зөвлөмж, шаардлагыг төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлсэнгүй. Тухайлбал, 2021 оны 1 дүгээр сард ХЭҮК-ын гишүүнээс Улсын Онцгой Комисст хандан E-barimt системд суурилсан QR бүртгэл нь цар тахлаас иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад гарцаагүй шаардлагатай, үр нөлөөтэй эсэх, зорилгодоо тохирсон эсэх талаарх үндэслэлийг олон нийтэд мэдээлэх, мөн халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах журмыг нэн даруй батлахыг шаардсан хэдий ч эдгээр шаардлагыг холбогдох байгууллагаас 2021 оны 5 дугаар сар хүртэл биелүүлээгүй байв.

Коронавируст халдвар (Ковид -19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтэд тусгайлан хяналт тавих үүрэг бүхий түр хороог УИХ-ын бүх Байнгын хороо болон УИХ дахь цөөнхийн төлөөллийг оролцуулан байгуулж, хуулийн биелэлтийг сар тутам нээлттэй хэлэлцэхээр хуульчилсан. УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор дээрх хороог байгуулсан хэдий ч уг хороо 2020 оны 11 дүгээр сарын 3-нд анх хуралдаж, Ковидын хуулийн биелэлт болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг сонссон. Түр хорооны анхны хуралдаан болон дараа дараагийн хуралдаанаар цар тахлын үед хууль сахиулах байгууллага тэр дундаа цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар тусгайлан сонссон талаарх мэдээлэл энэ тайлан хамрах хугацаанд олдсонгүй.

9.1. ЦАР ТАХЛЫН ҮЕД ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГОМДОЛ ГАРГАХ, ШИЙДВЭРЛЭХ, ХУУЛЬ ЗӨРЧСӨН АЛБА ХААГЧИД ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ МЕХАНИЗМ

Цар тахлын үед хүний эрхийг зөрчсөн, түүний дотор эрх мэдлээ урвуулан ашигласан, хүнийг хууль бусаар баривчилсан, бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдсэн хууль сахиулах байгууллагын алба хаагчийн асуудлыг үр дүнтэй, шуурхай шалгаж, хариуцлага хүлээлгэх шаардлагатай болохыг НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын газраас улс орнуудад зөвлөсөн.¹¹⁸

2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 1 дүгээр сарыг хүртэлх хугацаанд цагдаагийн алба хаагч чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хууль зөрчсөн талаар иргэн, хуулийн этгээдээс гомдол ирүүлсэн талаарх мэдээлэл цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдээгүй хэмээн Цагдаагийн Ерөнхий Газраас мэдээлсэн.¹¹⁹ Харин 2021 оны 3 дугаар сард ХЭҮК-оос УИХ-д

¹¹² <https://nhrcm.gov.mn/%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D/vact/>

¹¹³ <https://nhrcm.gov.mn/%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D/%D1%83%D0%BE%D0%BA-%D1%82/>

¹¹⁴ <https://nhrcm.gov.mn/%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D/%D0%BC%D0%B0%D1%8F%D0%B3%D1%82/>

¹¹⁵ <https://nhrcm.gov.mn/%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D/%D1%8D%D0%BC%D1%8F/>

¹¹⁶ ХЭҮК-оос Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Д.Загджавт хүргүүлсэн зөвлөмж, 2021.01.28 1/106.

¹¹⁷ ХЭҮК-оос Цагдаагийн Ерөнхий Газрын дарга Цагдаагийн хурандаа Ж.Болдод илгээсэн зөвлөмж, 2021.02.04 1/132.

¹¹⁸ United Nations Human Rights Office of the High Commissioner, Emergency measures and Covid-19: Guidance, 27 April 2020. chrome-extension://efaidnbmnnnibpcjpcglclefindmkaj/viewer.html?pdfurl=https%3A%2F%2Fwww.ohchr.org%2FDocuments%2FEvents%2FEmergencyMeasures_Covid19.pdf&clen=777416

¹¹⁹ Цагдаагийн Ерөнхий Газрын албан тоот 2021 оны 2 дугаар сарын 19, 2/68

хүргүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 20 дахь илтгэлд цагдаагийн алба хаагчид үүргээ гүйцэтгэх явцдаа эрх хэмжээгээ хэтрүүлсэн, бусадтай зүй бус харьцсан асуудлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 19 гомдолд цагдаагийн албаны дотоод шалгалт явуулж байгаа тухай бичжээ.¹²⁰ Ийнхүү цагдаагийн алба хаагч Ковид-19 цар тахлын үед хууль сахиулах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ иргэний эрхийг зөрчсөн талаарх мэдээлэл зөрүүтэй байгаа нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналт, мэдээллийн ил тод байдал хангагдаагүйг харууллаа.

2021 оны 9 дүгээр сард Цагдаагийн Ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээр 2020 оны 2 дугаар сараас 2021 оны 7 дугаар сарын хугацаанд цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд, байгууллагаас нийт 364 өргөдөл, гомдол ирүүлснээс 89 буюу 24.4 хувь нь хууль тогтоомж зөрчсөн нь шалгалтаар тогтоогдсон тул хуульд заасан хариуцлага хүлээлгэсэн, 275 буюу 75.5 хувьд алба хаагчийн буруутай үйл ажиллагаа нотлогдоогүй гэжээ.¹²¹ Иргэд, хуулийн этгээдээс цагдаагийн алба хаагчтай холбогдуулан гаргасан өргөдөл, гомдлын агуулгыг тодорхойлох боломжгүй байлаа.

Цар тахлын үе, ялангуяа гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед иргэд, байгууллагаас цагдаагийн хууль бус үйл ажиллагааны талаар гомдол, мэдээлэл гаргах арга, журам нь ойлгомжтой, тодорхой, хүртээмжтэй мэдээлэгдсэн эсэх, гомдол, мэдээллийг гаргах арга, журмыг цар тахлын үеийн онцлогт нийцүүлэн үр нөлөөтэй байдлаар өөрчилсөн эсэх нь тодорхойгүй байна.

Мөн цагдаагийн алба хаагчийн хууль зөрчсөн үйлдлийг тухайн цагдаагийн байгууллага өөрөө шалгаж байгаа нь хяналтын үр нөлөөг бууруулахын зэрэгцээ иргэдийн зөрчигдсөн эрх хамгаалагдахгүй байх, хууль зөрчсөн алба хаагчид хариуцлага хүлээлгэхгүй байх нөхцөлийг нэмэгдүүлж байна.

2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Хан-Уул дүүргийн нэгдүгээр хорооны нутаг дэвсгэрт нэгэн цагдаагийн албан хаагч коронавирусийн ойрын хавьтагч байж болзошгүй шинжилгээ өгөхөөс зайлсхийсэн гэх нэгэн иргэний биед халдаж, өшиглөж байгаа бичлэг олон нийтийн цахим сүлжээнд цацагдсан. Харин Хан-Уул дүүргийн цагдаагийн хэлтсээс уг албан хаагчтай холбоотой асуудлыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журмын дагуу албаны шалгалт явуулахад албан хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй хэмээн үзэж, шийдвэрлэжээ.¹²²

¹²⁰ Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл (2021), 80 дахь тал. http://forum.parliament.mn/projects/110762fbclid=IwAR1XMAPeD2-luvAqwXAJtHfBj32J5lvN4eZmb3X2mfFVZRw9l7bq_ES7-Ws

¹²¹ Цагдаагийн Ерөнхий Газрын 2021.09.07-ны өдрийн 2/333 тоот албан бичгийн хавсралт.

¹²² Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын албан тоот 2021 оны 3 дугаар сарын 9, 27/309

10. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Ковид-19 цар тахлын хямрал нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээгээр зохицуулагдах онцгой нөхцөл байдал бөгөөд бодлого, зохицуулалт нь нэн түрүүнд хүний эрхийг хүндэтгэсэн, баримт нотолгоонд суурилсан байх шаардлагатай. Тарваган тахлын халдвар зэрэг нийгмийн эрүүл мэндийн бусад хямралыг зохицуулж байсан сайн туршлагад үндэслэн хүний эрхийг дээдэлсэн, олон нийтийн итгэлцэл, эв нэгдлийг бий болгохуйц бодлогыг чухалчлах нь хямралыг давж гарахад ихээхэн үр дүнтэй. Албадлага хэрэглэх нь цар тахлын хариу арга хэмжээний үр нөлөөг бууруулах эрсдэлтэй тул зөвхөн зайлшгүй тохиолдолд, эцсийн арга хэрэгсэл болгон ашиглавал зохино.

Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ эрх баригчид олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд нийцсэн, нийтийн хэв журам хамгаалах зэрэг холбогдох байгууллага, албан тушаалтнуудын үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан хууль тогтоомж, журам, зааврыг боловсруулан гаргаж, эрх мэдлээ дур мэдэн, эсхүл хэтрүүлэн ашиглахад хүргэж болзошгүй нөхцлийг гаргахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай.

Нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээг үр дүнтэй болгохын тулд халдвар тархах эрсдэлээс гадна нийтийн хэв журам хамгаалах байгууллагын үйлдэх хүний эрхийн зөрчлөөс зайлсхийж, цагдаагийн алба хаагчид албадлагын аргаар бус иргэд өөрсдөө сайн дураар мөрдөх, харилцан хамтран ажиллах зарчмыг эн тэргүүнд баримтлан ажиллах нь зүйтэй.

Цар тахлаас урьдчилан сэргийлэхээр хязгаарлалт тогтоож буй учир шалтгаан болон хязгаарлалтын дэглэмийн талаарх мэдээлэл, зөвлөгөөг хүртээмжтэй арга хэрэгслээр олон нийтэд түгээх, хорио цээрийн дэглэмийг дагаж мөрдөхөд нь шаардлагатай дэмжлэг үзүүлэх, дэглэм зөрчсөнөөс үүдэн гарах хууль зүйн үр дагаврыг ойлгомжтой хэлбэрээр тайлбарлах (ялангуяа нийгэм, эдийн засгийн эмзэг бүлгийн иргэдэд мэдээлэл, зөвлөгөөг хүртээмжтэй, үр дүнтэй арга хэрэгслээр хүргэх) ёстой.

1. Аливаа цар тахал, гамшиг, онцгой байдлын үед шинээр боловсруулан гаргах болон нэмэлт өөрчлөлт оруулж байгаа хууль тогтоомж, бодлого, журам нь олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд нийцсэн байхыг баталгаажуулах, хуулийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих. Үүнд:

- Хууль сахиулах байгууллага, түүний алба хаагчдын гамшгийн үед ажиллах чиг үүрэг, хариуцлагыг тодорхой зохицуулсан хууль, дүрэм, журмыг хүний эрхийн олон улсын хууль, хэм хэмжээ, НҮБ болон бусад хүний эрхийн байгууллагаас өгч буй зөвлөмжид нийцүүлэн батлах;
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар хамгаалагдсан тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөнд үндэслэлгүй, хэт хязгаарлалт тавих боломж олгож байгаа хууль тогтоомжийг хүчингүй болгох, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд нийцүүлэн сайжруулах;
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хумьсан, хязгаарласан бодлого, хууль тогтоомж, зүйл заалтыг хүчингүй болгох, хүний эрхийн хууль, хэм хэмжээнд нийцүүлэн сайжруулах, “хуурамч мэдээ”, “ташаа мэдээлэл” гэх зэрэг ойлгомжгүй, хоёрдмол санаа бүхий нэр томъёог хуульд хэрэглэхгүй байх;
- Онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь үр дүнтэй бөгөөд хэр хэмжээнд тохирсон эсэхэд тогтмол хяналт тавих. Үүний тулд Засгийн газар болон Улсын онцгой комисс зэрэг холбогдох төрийн байгууллагаас цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, шийдвэрт хууль тогтоох болон шүүх эрх мэдэл бүхий байгууллагаас хараат бус, хөндлөнгийн үр дүнтэй хяналт тавих механизмыг бүрдүүлэх;
- Коронавируст халдвар (Ковид -19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын тавдугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлж, үр дүнг олон нийтэд мэдээлэх;

- Аливаа цар тахлын үеийн хариу арга хэмжээг хэрэгжүүлж байгаа хууль сахиулах алба хаагчдыг олон улсын стандартад нийцсэн хувийн хамгаалах хэрэгслээр хангах, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн нөхцөлийг нь олон улсын хүний эрхийн хууль хэм хэмжээнд нийцүүлэх төрийн үүргийг баталгаажуулах.

2. Хууль сахиулах байгууллага, алба хаагчид хорио цээрийн дэглэм, журмыг хэрэгжүүлэхдээ хүлээцтэй хандан ашиг сонирхлоо сайтар тэнцвэржүүлэх, эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ хүний эрхийг хязгаарлахад баримтлах үндсэн зарчим болох зайлшгүй шаардлагатай байх, хэр хэмжээ нь тохирсон байх зэргийг баримтлах үүрэгтэй.

Баривчлах, цагдан хорих, жагсаал цуглааныг албадан тараах, бусад хэлбэрээр хүч, албадлага хэрэглэх нь цар тахлын халдвар тархах эрсдэлийг улам нэмэгдүүлнэ. Иймээс дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгод нийцэж байгаа эсэх, хангалттай үр дүнтэй байж чадах эсэхийг үнэлэх шаардлагатай. Гагцхүү хорио цээрийн дэглэмийг зөрчсөн гэх үндэслэлээр иргэдийг баривчлан, цагдан хорих нь эсрэгээрээ халдвар тархах эрсдэлийг улам нэмэгдүүлэх тул аль болох эдгээр таслан сэргийлэх арга хэмжээнээс зайлсхийх шаардлагатай. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах нэрийн дор үйлдсэн аливаа хууль бус үйлдэл, арга хэмжээг ямар ч байдлаар зөвтгөх боломжгүй. Үүнд:

- Хууль сахиулах байгууллагын албан тушаалтан, алба хаагчдад аливаа үйл ажиллагаандаа хүний эрхийн олон улсын хэм хэмжээ, зарчмыг баримтлан ажиллах талаар шинэчилсэн сургалтыг тогтмол явуулах;
- Халдвар тархахаас сэргийлж, цагдан хорих арга хэмжээ, баривчлах шийтгэл ногдуулахаас аль болох татгалзах, нэн ялангуяа архаг суурь өвчинтэй, өндөр настан зэрэг халдварт өртөх өндөр эрсдэлтэй хүмүүсийг цагдан хорихоос зайлсхийх;
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авах, хорио цээрийн дэглэм сахиулах журам зөрчсөн хүмүүсийг гутаан доромжлох, эсхүл бусад хэрцгий, хүнлэг бус байдлаар харьцахаас зайлсхийх;
- Хорио цээрийн дэглэм зөрчсөн үйлдэлд оногдуулсан аливаа шийтгэл нь хууль дээдлэх, үндэслэл бүхий байх, зайлшгүй байх гэх зэрэг зарчимд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах;
- Цагдаа хууль сахиулах үйл ажиллагаа явуулахдаа нэр болон тусгай дугаар бүхий тэмдэгтэй, дүрэмт хувцастай байж, шууд таних, тодорхойлох боломжтой байхыг баталгаажуулах;
- Хязгаарлалт тогтоож буй үндэслэл шалтгаан, хязгаарлалтын дэглэмийн талаарх мэдээлэл, зөвлөгөөг олон нийтэд хүртээмжтэй арга хэрэгслээр түгээх, хорио цээрийн дэглэмийг мөрдөхөд нь шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх, дэглэм зөрчсөнөөс үүдэн гарах хууль зүйн үр дагаврыг ойлгомжтой хэлбэрээр тайлбарлах (ялангуяа нийгэм, эдийн засгийн эмзэг бүлгийн иргэдэд мэдээлэл, зөвлөгөөг хүртээмжтэй, үр дүнтэй арга хэрэгслээр хүргэх гэх мэт);
- Хүний туйлын эрхээс бусад эрхийг хуулиар хязгаарлах бөгөөд энэ нь зөвхөн гарцаагүй үндэслэл бүрдсэн үед тухайн нөхцөл байдлын хэр хэмжээнд нийцүүлэн хэрэгжүүлэх хуулийн зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх;
- Цар тахлын эсрэг хариу арга хэмжээнд технологийн ололт амжилтыг ашиглаж болох ч энэ нь зорилгод хүрэхэд зайлшгүй шаардлагатай байхаас гадна хүний хувийн нууцад халдахгүй байхыг баталгаажуулах.

Хууль сахиулах байгууллага, алба хаагчид бүхий л үйл ажиллагаандаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хангаж ажиллах. Үүнд:

- Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг хэрэгжүүлэхдээ иргэдэд, ялангуяа нийгэм, эдийн засгийн эмзэг бүлгийн иргэд болох үндэсний цөөнх, ЛГБТИ хүмүүс, хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, шилжин суурьшигч, орон гэргүй гэх мэт иргэдтэй зүй бусаар хандахаас урьдчилан сэргийлэх;
- Ковидын халдвар авсан, ойрын болон дам хавьталд орсон, түүнчлэн хязгаарлалтын дэглэм зөрчсөн иргэдийн хувийн мэдээллийн нууцлалыг хангаж, аливаа алагчлал, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс сэргийлэх;

Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах онцгой нөхцөл байдлыг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх зэрэг Үндсэн хууль болон олон улсын хэм хэмжээгээр хамгаалагдсан хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчих, хязгаарлах арга хэрэгсэл болгон ашиглахгүй байхыг баталгаажуулах. Үүнд:

- Цар тахлын үед жагсаал, цуглаан хийх эрхэд үнэмлэхүй хязгаарлалт тогтоож болохгүй. Жагсаал цуглаан хийх эрхийг хязгаарлах, цагдаагийн албадлага хэрэглэн тараах арга хэмжээг гагцхүү зайлшгүй шаардлагад үндэслэсэн эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх, жагсаал, цуглааныг албадан тараахдаа хуульд заасан шударга процедурын дагуу зохион байгуулах;
- Аливаа цар тахал, хямралын үед халдвар, хамгааллын дэглэм болон хүн хоорондын зай барьж, тайван замаар явагдаж буй жагсаал, цуглаан, ганц хүний суулт зэргийг эрх бүхий байгууллагад мэдэгдлээ бүртгүүлээгүй гэх үндэслэлээр цагдаагийн хүч албадлага хэрэглэн тараахгүй байх;
- Талуудын тайван замаар хуран цуглах эрх чөлөөг хангахын тулд жагсаал зохион байгуулагчидтай урьдчилж, эсвэл жагсаалын үеэр газар дээр нь холбоо тогтоож, итгэлцэл, хариу арга хэмжээ авах харилцаа холбооны сувгийг бий болгох;
- Зөрчилдөөнтэй бүлгүүдийн хоорондох хурцадмал байдлыг дэвэргэлгүйгээр аливаа хүчирхийлэл, мөргөлдөөний эрсдэлд хариу арга хэмжээ авахын тулд зохих ёсоор бэлтгэгдсэн хангалттай тооны цагдаагийн албан хаагчдыг ажиллуулах;
- Олон нийтийн эсэргүүцэл, дургүйцлийг нэмэгдүүлэх, хүчирхийллийг улам өдөөх тул цагдаагийн хүчний бие бүрэлдэхүүнийг хэт олон тоогоор дайчлах, жагсаал цуглааныг хүчээр тараах хэт нүсэр хэрэгслийг ашиглаж, айлган сүрдүүлэхийн оронд, тусалж дэмжсэн арга замыг сонгох;
- НҮБ-ын Тайван замаар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч, Шүүхээс гадуур, дур зоргоор цаазлах асуудал хариуцсан Тусгай илтгэгч нарын хамтран боловсруулсан Жагсаал, цуглааныг зохицуулах талаарх зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах хуудсыг ашиглан жагсаал, цуглааны харилцааг зохицуулж байгаа эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагаа, практикт дүн шинжилгээ хийх, үнэлгээнд үндэслэн эрх зүйн орчин болоод зохицуулалтыг сайжруулах

Нийгмийн эрүүл мэндийн хямралыг даван туулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг зөрчиж, ашиг сонирхолд нь хууль бусаар халдсан бол нийтийн хэв журам хамгаалах үүрэг хүлээсэн төрийн байгууллага болон холбогдох албан тушаалтнуудад зохих хууль ёсны хариуцлагыг зайлшгүй хүлээлгэх. Үүнд:

- Цар тахлын үед, ялангуяа гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд цагдаагийн байгууллагаас албадлага хэрэглэх нөхцөл, журмын талаар олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэхийн зэрэгцээ, хууль зөрчсөн цагдаагийн албан хаагчийн талаарх гомдол, мэдээллийг хаана, ямар журмаар гаргах талаарх мэдээллийг хүртээмжтэй, тодорхой давтавтайгаар өгөх;
- Хүний эрхийг зөрчсөн, эсхүл зөрчсөн байж болзошгүй төрийн байгууллага, алба хаагчдын хууль бус үйлдэл, арга хэмжээтэй холбогдуулан хараат бус мөрдөн шалгах ажиллагааг явуулж, гэм буруутай болох нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд зохих ял шийтгэлийг оногдуулах;
- Төрийн байгууллага, албан хаагчдын буруутай үйл ажиллагааны улмаас эрх нь зөрчигдсөн этгээдийн эрхийг сэргээх, нөхөн төлбөр олгох механизмыг бодитойгоор хэрэгжүүлэх;

Холбоо барих



mongolia.amnesty@gmail.com



+976 7000 4708



[www.facebook.com/ Amnesty International
Mongolia - Монголын Эмнести Интернэшнл](https://www.facebook.com/AmnestyInternationalMongolia)



[@AmnestyOnline](https://twitter.com/AmnestyOnline)

